



**ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАР**

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДЛААР ХИЙСЭН ТАНДАЛТ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар

2026 он

Хянасан: Тандалт судалгаа, бодлого төлөвлөлтийн газрын дарга
Н.Баярмаа

Судалгааны баг: Тандалт судалгаа, бодлого төлөвлөлтийн газрын
Эрсдэлийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч Х.Оюунчимэг

Тандалт судалгаа, бодлого төлөвлөлтийн газрын
Бодлогын судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн
референт С.Рэгзэн

Тандалт судалгаа, бодлого төлөвлөлтийн газрын
Эрсдэлийн удирдлагын хэлтсийн ахлах шинжээч
Д.Ган-Оюун

Тандалт судалгаа, бодлого төлөвлөлтийн газрын
Эрсдэлийн удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн
Б.Доржханд

Үнэлгээ, мониторингийн газрын Үр дүнгийн
шинжилгээний хэлтсийн Судалгаа, шинжилгээний
ажилтан Х.Наранцацрал

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	4
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ.....	5
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРТГАЛ.....	7
Нэг. Судалгааны үндэслэл	7
Хоёр. Судалгааны зорилго	8
Гурав. Судалгааны зорилт.....	8
Дөрөв. Судалгааны арга зүй	8
ХОЁРДУГААР БҮЛЭГ. САЛБАРЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧДЫН ТАНДАЛТ СУДАЛГАА.....	11
2.1.Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл	11
2.2.Судалгааны үндсэн мэдээлэл	15
2.3.Хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох талаарх санал	35
2.4.Бүлгийн дүгнэлт	36
2.5.Хуулийн төсөлд тусгах санал.....	37
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТАНДАЛТ СУДАЛГАА..	38
3.1.Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл	38
3.2.Судалгааны үр дүн.....	40
3.3.Бүлгийн дүгнэлт:	52

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.Нийт салбарын хяналтын болон судалгаанд хамрагдсан байцаагчийн тоо.....	14
Хүснэгт 2.....	15
Хүснэгт 3.Хяналт шалгалтын тогтолцоог бололвсронгуй болгох санал, дүнд эзлэх хувиар	35
Хүснэгт 4.Судалгаанд хамрагдсан иргэн, хуулийн этгээдийн тоо, салбараар	38
Хүснэгт 5.Судалгаанд хамрагдагчдын тухайн салбарт ажилласан хугацаа, тоо, хувиар.....	39
Хүснэгт 6.Мэргэжлийн хяналтын тогтолцооны талаар иргэд, хуулийн этгээдээс авах судалгааны асуулт, хариултын тоо, агуулга	40
Хүснэгт 7.Хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох санал, дүнд эзлэх хувиар.....	51

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1.Судалгаанд хамрагдсан байцаагчдын хүйсийн байдал	11
График 2.Судалгаанд хамрагдсан байцаагчдын насны бүтэц, хувиар.....	11
График 3.Судалгаанд хамрагдсан албан хаагчдын боловсролын түвшин	12
График 4.Судалгаанд хамрагдсан албан хаагчдын хяналтын салбарт ажилласан хугацаа	12
График 5.Судалгаанд хамрагдсан байцаагчдын байгууллагын төрөл, хүйсээр ..	13
График 6.Судалгаанд хамрагдсан байцаагчдын албан тушаалын төрөл	13
График 7.Судалгаанд хамрагдсан байцаагчдын албан тушаалын төрөл	13
График 8.Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарт нь шилжүүлснээр бий болсон үр дагавар/үр нөлөө, хувиар	16
График 9.Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарт нь шилжүүлснээр бий болсон үр дагавар/үр нөлөөг үнэлсэн байдал, хяналтын байцаагчдын ажилласан хугацаагаар, хариултын тоогоор.....	17
График 10.Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарт нь шилжүүлснээр “Хяналт шалгалтыг салбарын бодлоготой уялдуулах боломжтой болсон” хариулт, хувиар, салбараар.....	18
График 11.Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарт нь шилжүүлснээр “Төсөв, санхүүжилт сайжирсан” хариулт, хувиар, салбараар	19
График 12.Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарт нь шилжүүлснээр “Цалин хөлс нэмэгдсэн” хариулт, хувиар, салбараар.....	20
График 13.Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарт нь шилжүүлснээр “Ажиллах орчин, нөхцөл сайжирсан” хариулт, хувиар, салбараар.....	21
График 14.Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарт нь шилжүүлснээр “Хяналт шалгалтын хараат бус байдал сайжирсан” хариулт, хувиар, салбараар	22
График 15.Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарт нь шилжүүлснээр “Нэгдсэн бодлого, арга зүйтэй болсон” хариулт, хувиар, салбараар	24
График 16.Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарт нь шилжүүлснээр “Хяналт шалгалтын давхардал багассан” хариулт, хувиар, салбараар	25
График 17.Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарт нь шилжүүлснээр “Хүний нөөцийн бодлого сайжирсан” хариулт, хувиар, салбараар	26
График 18.Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарт нь шилжүүлснээр “Мэргэжлийн хяналтын нэр хүнд сайжирсан” хариулт, хувиар, салбараар	27
График 19.Мэргэжлийн хяналтын нэгдсэн тогтолцооны талаар хариулсан байдал, байгууллагаар	28
График 20.Мэргэжлийн хяналтын нэгдсэн тогтолцооны талаар хариулсан байдал, хяналтын чиглэлээр, тоогоор	29
График 21.Мэргэжлийн хяналтын нэгдсэн тогтолцооны талаарх судалгаанд оролцогчдын байр суурь, хувиар	30
График 22.Мэргэжлийн хяналтын нэгдсэн тогтолцооны талаар хариулсан байдал, хяналтын байцаагчдын ажилласан хугацаагаар, хувиар.....	31
График 23.Мэргэжлийн хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлснээр гарах үр дүнгийн талаарх хариулт, хувиар.....	32
График 24.Мэргэжлийн хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлснээр гарах үр дүнгийн талаарх үзэл бодол, ажилласан хугацаа, хувиар	33
График 25.Салбарын хяналтын хэлбэрээр ажиллуулахыг дэмжсэн шалтгааныг тодорхойлсон байдал, нэгтгэл, тоогоор	34

График 26.Судалгаанд хамрагдагчдын нас, хүйсийн бүтэц, тоогоор	38
График 27.Иргэн, хуулийн этгээдийн сүүлийн 3 жилд салбарын хяналтын байгууллагатай хамтран ажилласан байдал, тоогоор	42
График 28.Иргэн, хуулийн этгээдийн сүүлийн 3 жилд салбарын хяналтын байгууллагатай хамтран ажилласан байдал, хувиар	43
График 29.Үйлчилгээ авсан иргэн, хуулийн этгээдийн салбарын хяналтын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ, хувиар.....	44
График 30.Сүүлийн 3 жилийн хугацаанд жилд дундажаар иргэн, хуулийн этгээдийн хяналт шалгалтад хамрагдсан байдал, хувиар	45
График 31.Иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хийж байгаа хяналт шалгалт хүндрэл учирдаг эсэх, хувиар	45
График 32.Иргэний үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх хүрээнд учирдаг хүндрэлийг үнэлсэн байдал, тоогоор	46
График 33.Мэргэжлийн хяналтыг татан буулгаснаар үүссэн үр дагаврын талаарх иргэн, хуулийн этгээдийн үнэлгээ, хувиар.....	47
График 34.Мэргэжлийн хяналтыг дахин байгуулах эсэх талаарх иргэн, хуулийн этгээдийн үзэл бодол, хувиар	48
График 35.Мэргэжлийн хяналтыг дахин байгуулснаар гарах үр нөлөөг иргэн үнэлсэн байдал, тоогоор	49
График 36.Хяналтын тогтолцооны талаарх иргэн, хуулийн этгээдийн үзэл бодол, тодорхойлсон байдал, тоогоор	50

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРТГАЛ

Нэг. Судалгааны үндэслэл

Монгол Улсад төрийн хяналт шалгалтын тогтолцоо нь иргэн, аж ахуйн нэгжийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн буй орчин, эдийн засгийн тогтвортой байдлыг хамгаалах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг.

2022 онд мэргэжлийн хяналтын байгууллагын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орж, хяналтын чиг үүргийг салбарын яам, зарим агентлагт шилжүүлсэн нь хяналт шалгалтын тогтолцооны уялдаа холбоо, нэгдсэн бодлого, арга зүйн удирдлага, хяналтын үр нөлөө, улсын байцаагчдын чадавх, хариуцлагын тогтолцоо суларч тодорхой хүндрэл, бэрхшээлийг бий болгосон.

Үүний зэрэгцээ хяналт шалгалтын давхардал, хүндрэл чирэгдэл, мэдээллийн нэгдсэн сангийн ашиглалт, эрсдэлд суурилсан төлөвлөлт, зөвлөн туслах үйлчилгээ, хяналтын үр дүнгийн үнэлгээ зэрэг асуудлыг боловсронгуй болгох шаардлага тулгарч байна.

Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан, иргэн, аж ахуйн нэгжид ээлтэй, торгох бус зөвлөн туслах, урьдчилан сэргийлэх чиглэлтэй болгон шинэчлэх, төрийн хяналт шалгалтын эрх зүйн орчныг шинэчлэн боловсронгуй болгохоор ажиллаж байна.

Иймд мэргэжлийн хяналтын тогтолцооны өнөөгийн нөхцөл байдал, чиг хандлага, цаашид сайжруулах санал, байр суурь, мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарт нь шилжүүлснээр бий болсон үр дагавар/үр нөлөө, мэргэжлийн хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлснээр гарах үр дүн, салбарын хяналтын хэлбэрээр ажиллуулах, тулгамдсан асуудал болон цаашид хэрэгжүүлэх боломжит хувилбарыг судлах, бүтэц, зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгох дүгнэлт, санал боловсруулах зорилгоор энэхүү тандалт судалгааг хийв.

Энэхүү судалгааны үр дүн нь төрийн хяналт шалгалтын тогтолцоог шинэчлэх бодлого боловсруулах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох ач холбогдолтой юм.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 114 дүгээр тогтоолоор Засгийн газарт төрийн хяналт шалгалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, төрийн хяналтын тогтолцоог оновчтой зохион байгуулах, эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог бүрдүүлэх чиглэл өгсөн. Түүнчлэн "Алсын хараа–2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, иргэн, аж ахуйн нэгжид ээлтэй зохицуулалтын орчныг бүрдүүлэх, эрсдэлд суурилсан, урьдчилан сэргийлэх, цахим хяналтын тогтолцоог хөгжүүлэх зорилтыг тусгасан бөгөөд эдгээр зорилтыг хэрэгжүүлэхэд төрийн хяналтын тогтолцоог шинэчлэх шаардлага үүсээд байна.

Хоёр. Судалгааны зорилго

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг шинэчлэн боловсруулах хүрээнд мэргэжлийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгох асуудлаар бүх салбар, шатны мэргэжлийн хяналтын байцаагч, иргэд, хуулийн этгээдийн санал бодлыг тандах замаар хуулийн төсөлд тусгах асуудлыг боловсруулахад оршино.

Гурав. Судалгааны зорилт

3.1. Бүх салбар, чиглэлийн хяналтын байцаагчийн төлөөллөөс салбарын хяналтын давуу болон сул тал, цаашид хяналт шалгалтын тогтолцоог хэрхэн бүрдүүлэх асуудлаар тандан судлах

3.2. Иргэн, хуулийн этгээдээс 3 жилийн хугацаанд салбарын хяналтын байгууллагатай хэрхэн хамтран ажилласан, мэргэжлийн хяналтыг татан буулгаснаар бий болсон үр дагавар, цаашид хяналтын тогтолцоог боловсронгуй болгох саналыг тандан судлах

3.3. Салбарын хяналтын байцаагч, иргэн, хуулийн этгээдийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгох саналыг нэгтгэн боловсруулж, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах

Дөрөв. Судалгааны арга зүй

4.1. Судалгааны хамрах хүрээ

Энэхүү судалгаа нь хяналт шалгалтын үйл ажиллагаанд оролцогч талуудын санал, үнэлгээ, туршлагыг тодорхойлох зорилгоор байцаагч болон иргэн, хуулийн этгээдийг хамруулан зохион байгуулагдсан. Судалгаанд хяналт шалгалтын чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллагуудын байцаагчид, түүнчлэн хяналт шалгалтын үйл ажиллагаатай харилцаж байсан иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл оролцсон.

4.2. Мэдээлэл цуглуулсан арга

Судалгааны асуулгыг Microsoft Forms платформ ашиглан цахим хэлбэрээр боловсруулж, салбарын хяналтын байцаагчийн мэдээллийг 2026 оны 6 дугаар сарын 26-аас 6 дугаар сарын 30, иргэн, хуулийн этгээдийн мэдээллийг 6 дугаар сарын 26-аас 7 дугаар сарын 5-ны өдрийн хооронд цуглуулсан.

Байцаагчдад зориулсан асуулгыг холбогдох яам, агентлагаар дамжуулан хүргүүлж, судалгаанд оролцох боломжийг бүрдүүлсэн. Байцаагчдын хувьд нийт хамрагдах боломжтой ажилтнуудын 50-иас доошгүй хувийг хамруулах зорилт тавьж ажилласан.

Иргэн, хуулийн этгээдэд тэдний хандалт ихтэй Нийгмийн даатгалын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын веб сайт, и-монголиа төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системээр судалгаанд хамрагдах холбоосыг хүргэсэн. Мөн Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Монголын ажил олгогч эздийн холбоогоор дамжуулан гишүүн байгууллагын төлөөллийг хамруулсан.

4.3.Түүвэрлэлтийн арга

Судалгаанд оролцогчдыг сонгохдоо зорилтот болон сайн дурын түүвэрлэлтийн аргыг хослуулан ашигласан. Байцаагчдын судалгаанд зорилтот түүвэрлэлтийн (purposive sampling) аргыг хэрэглэсэн. Судалгааны зорилго, хамрах хүрээнд хамаарах байцаагчдыг оролцуулахын тулд асуулгыг албаны шугамаар түгээж, нийт байцаагчдын 50-иас доошгүй хувийг хамруулах зорилт тавьсан. Энэхүү арга нь хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж буй албан хаагчдын санал, туршлага, үнэлгээг хангалттай хэмжээнд тусгах боломжийг бүрдүүлсэн.

Иргэн, хуулийн этгээдийн судалгаанд сайн дурын буюу өөрөө сонгон оролцох түүвэрлэлтийн (voluntary response/self-selection sampling) аргыг ашигласан. Судалгааны асуулгыг төрийн байгууллагуудын цахим хуудас болон и-монголиа төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан олон нийтэд нээлттэй байршуулж, оролцох хүсэлтэй иргэн, хуулийн этгээдүүд сайн дурын үндсэн дээр хамрагдсан. Энэ бүлгийн хувьд урьдчилан тогтоосон түүврийн хэмжээ болон төлөөллийн квот тогтоогоогүй бөгөөд судалгаанд аль болох олон оролцогчийг хамруулахыг зорьсон.

Үүний үр дүнд судалгаанд нийт 11,284 хүн оролцсоноос 1,006 байцаагч, 9,981 иргэн, 297 хуулийн этгээдийн төлөөлөл хамрагдсан болно.

4.4.Өгөгдөл боловсруулах, шинжлэх арга

Судалгааны мэдээллийг Microsoft Forms платформоос татан авч нэгтгэн боловсруулсан. Өгөгдөлд анхан шатны шалгалт хийж, дутуу болон давхардсан мэдээллийг хянаж цэвэрлэн статистик боловсруулалт хийсэн.

Судалгааны үр дүнг давтамж, хувь хэмжээ болон бүлэг хоорондын харьцуулалтын аргаар нэгтгэн шинжилж, оролцогчдын санал, үнэлгээ, тулгамдсан асуудал, сайжруулах чиглэлийг тодорхойлсон.

4.5 Судалгааны итгэлцлийн түвшин, алдааны хязгаар

Байцаагчдын судалгаанд нийт 1,823 байцаагчаас 1,006 нь оролцсон бөгөөд энэ нь нийт эх олонлогийн 55.2 хувь нь болж байна. Ийнхүү нийт байцаагчдын талаас илүү хувийг хамруулсан нь судалгааны үр дүнгийн найдвартай байдлыг нэмэгдүүлж, байцаагчдын санал, үнэлгээг бодитой тусгасан гэж үзэх үндэстэй.

Судалгааны статистикийн нарийвчлалыг үнэлэхдээ нийгмийн шинжлэх ухааны судалгаанд өргөн хэрэглэгддэг 95 хувийн итгэлцлийн түвшинг сонгосон. Энэхүү түвшин нь үр дүнгийн найдвартай байдал болон тооцооны нарийвчлалын хоорондын оновчтой тэнцвэрийг хангадаг олон улсын нийтлэг стандарт бөгөөд 5 хувийн эрсдэлийг зөвшөөрсөн нөхцөлд тооцоог хийдэг. Судалгааны түүврийн статистикийн нарийвчлалыг үнэлэх зорилгоор 95 хувийн итгэлцлийн түвшинг

ашиглан ($Z = 1.96$), хамгийн их хэлбэлзэлтэй нөхцөл болох $p = 0.5$, $q = 0.5$ гэж үзэн, эх олонлогийн засварын коэффициентийг (Finite Population Correction, FPC) хэрэглэн дараах байдлаар тооцлоо. Үүнд:

- Нийт эх олонлог (N) = 1,823
- Судалгаанд хамрагдсан (n) = 1,006
- Итгэлцлийн түвшин = 95%
- $Z = 1.96$
- $p = 0.5$
- $q = 1 - p = 0.5$

Түүврийн стандарт алдаа (Standard Error)

$$SE = \sqrt{\frac{p \cdot q}{n}} = \sqrt{\frac{0.5 \cdot 0.5}{1006}} = 0.01576$$

Эх олонлогийн засварын коэффициент

$$FPC = \sqrt{\frac{N-n}{N-1}} = \sqrt{\frac{1823-1006}{1823-1}} = 0.6696$$

Засварласан стандарт алдаа

$$SE_{adj} = SE \cdot FPC = 0.01576 \cdot 0.6696 = 0.01055$$

4. Алдааны хязгаар (Margin of Error)

$$ME = Z \cdot SE_{adj} = 1.96 \cdot 0.01055 = 0.02068$$

$$ME = \pm 2.07\% \approx \pm 2.1\%$$

Тооцооны дүн

Үзүүлэлт	Утга
Нийт эх олонлог (N)	1,823
Түүврийн хэмжээ (n)	1,006
Хамрагдалтын түвшин	55.2%
Итгэлцлийн түвшин	95%
Z-утга	1.96
Стандарт алдаа	0.01576
Эх олонлогийн засварын коэффициент	0.6696
Засварласан стандарт алдаа	0.01055
Алдааны хязгаар	$\pm 2.07\%$ ($\approx \pm 2.1\%$)

"Байцаагчдын судалгаа нь зорилтот түүвэрлэлтийн аргад үндэслэсэн тул 95 хувийн итгэлцлийн түвшин, ± 2.1 хувийн алдааны хязгаарыг статистикийн лавлах үзүүлэлт болгон тооцож ашиглав." Энэхүү үзүүлэлт нь нийгэм, бодлогын судалгаанд өргөн хэрэглэгддэг 95%-ийн итгэлцлийн түвшинтэй, $\pm 3\%$ -иас бага алдааны хязгаар гэсэн сайн чанарын шалгуурыг хангаж байгаа бөгөөд байцаагчдын судалгааны үр дүнг өндөр найдвартай гэж үзэх үндэслэл болно.

Харин иргэн, хуулийн этгээдийн судалгаанд сайн дурын (voluntary response/self-selection) түүвэрлэлтийн аргыг ашигласан тул эдгээр бүлгийн хувьд уламжлалт статистикийн итгэлцлийн түвшин болон алдааны хязгаарыг тооцох нь арга зүйн хувьд тохиромжгүй. Иймээс уг бүлгийн үр дүнг нийт хүн амд статистикийн утгаар ерөнхийлөн дүгнээгүй бөгөөд зөвхөн судалгаанд сайн дурын үндсэн дээр оролцсон иргэн, хуулийн этгээдийн санал, үнэлгээг илэрхийлсэн болно.

4.6.Судалгааны хязгаардмал тал


Байцаагчдын судалгаанд зорилтот хамрагдалтын арга ашигласан бол иргэн, хуулийн этгээдийн судалгаа нь сайн дурын оролцоонд тулгуурласан тул үр дүн нь нийт иргэн, хуулийн этгээдийн үзэл бодлыг статистикийн хувьд бүрэн төлөөлөхгүй байж болно. Иймд судалгааны үр дүнг хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой оролцогчдын санал, туршлага, хандлагыг тодорхойлох зорилгоор тайлбарлаж ашигласан болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. САЛБАРЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧДЫН ТАНДАЛТ СУДАЛГАА

2.1.Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл


Судалгаанд хамрагдсан нийт 1006 байцаагчийн 578 буюу 57.4 хувь нь эмэгтэй, 423 буюу 42.0 хувь нь эрэгтэй байсан ба 5 буюу 0.49 хувь нь хүйсийн мэдээллээ өгөхөөс татгалзаж, хариулахгүй гэсэн сонголтыг хийсэн байна.

График 1.Судалгаанд хамрагдсан байцаагчдын хүйсийн байдал




Судалгаанд хамрагдсан байцаагчийн 17 буюу 2 хувь нь 19-24, 246 буюу 24.4 хувь нь 25-34, 380 буюу 38.0 хувь нь 35-44, 289 буюу 29.0 хувь 45-54, 74 буюу 7.0 хувь нь 55 ба түүнээс дээш насны албан хаагчид байна.

График 2.Судалгаанд хамрагдсан байцаагчдын насны бүтэц, хувиар




Судалгаанд хамрагдсан байцаагчдын 66.2 хувь буюу 666 нь бакалавр, 3.4 хувь буюу 35 нь дипломын дээд, 0.59 хувь буюу 6 нь доктор ба түүнээс дээш, 29.6 хувь буюу 298 нь магистр, 1 нь мэргэжлийн болон техникийн боловсролтой албан хаагчид байна.

График 3. Судалгаанд хамрагдсан албан хаагчдын боловсролын түвшин



Судалгаанд хамрагдагчдын 56 буюу 5.5 хувь нь 1 хүртэл жил, 218 буюу 22 хувь нь 1-3 жил, 259 буюу 26.0 хувь нь 4-9 жил, 153 буюу 15.2 хувь 10-14 жил, 149 буюу 15.0 хувь нь 15-19 жил, 171 буюу 17.0 хувь нь 20-оос дээш жил тус тус ажилласан байна.


График 4. Судалгаанд хамрагдсан албан хаагчдын хяналтын салбарт ажилласан хугацаа



Судалгаанд хамрагдсан байцаагчдыг байгууллагын төрлөөр нь авч үзвэл 60 нь яаманд, 248 нь агентлагт, 322 нь аймаг, нийслэлийн газар/хэлтэст, 26 нь сум/дүүргийн нэгжид, 105 нь аймаг, нийслэлийн ЗДТГ, 78 нь Засаг даргын


дэргэдэх агентлагт, 146 нь сум, дүүргийн ЗДТГ-т, 21 нь бусад байгууллагад ажиллаж байна.

График 5. Судалгаанд хамрагдсан байцаагчдын байгууллагын төрөл, хүйсээр




Судалгаанд хамрагдсан байцаагчдыг албан тушаалаар нь авч үзвэл улсын ерөнхий байцаагч 3, улсын ахлах байцаагч 250, улсын байцаагч 753 байна.

График 6. Судалгаанд хамрагдсан байцаагчдын албан тушаалын төрөл



Судалгаанд хамрагдсан байцаагчдын 37 буюу 3.6 хувь нь аж үйлдвэр, эрдэс баялгийн, 136 буюу 13.5 хувь нь байгаль орчны, 46 буюу 4.5 хувь нь барилга, хотын байгуулалтын, 32 буюу 3.1 хувь нь боловсролын, 27 буюу 2.6 хувь нь Газар, геодези, зураг зүйн, 72 буюу 7.1 хувь нь Зам, тээврийн, 19 буюу 1.8 хувь нь Мэдээлэл, харилцаа холбооны, 5 буюу 0.49 хувь нь Соёл, соёлын өв, аялал жуулчлалын, 16 буюу 1.5 хувь нь Хилийн хорио цээр, 119 буюу 11.8 хувь нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын, 311 буюу 30.9 хувь нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн, 23 буюу 2.2 хувь нь Хэмжил зүйн, 139 буюу 13.8 хувь нь Эрүүл мэндийн, 21 буюу 2.0 хувь нь Эрчим хүчний ХЯНАЛТЫН салбарт тус тус ажиллаж байна.

График 7. Судалгаанд хамрагдсан байцаагчдын албан тушаалын төрөл



Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас 2026 оны 01 дүгээр сарын байдлаар улсын хэмжээнд салбарын хяналтын чиглэлээр 1823 байцаагч ажиллаж буй гэсэн судалгаа гарсан байх бөгөөд тус судалгаанд 1006 байцаагч буюу нийт байцаагчдын 55.1 хувь нь хамрагдсан байна.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан байцаагчийн тоо

№	Салбар/чиглэл	Судалгаанд хамрагдсан байцаагчийн тоо
1	Эрүүл мэндийн салбар	139
1.1	Эм, био бэлдмэлийн хяналт	28
1.2	Эмчилгээний чанар, аюулгүй байдлын хяналт	21
1.3	Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналт	90
2	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар	119
2.1	Нийгмийн хамгааллын хяналт	31
2.2	Хөдөлмөрийн хяналт	63
2.3	Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналт	25
3	Барилга, хот байгуулалтын салбар	46
3.1	Барилга байгууламжийн техникийн хяналт	9
3.2	Барилга, өргөх байгууламжийн техникийн хяналт	7
3.3	Барилгын техникийн хяналт	30
4	Эрчим хүчний салбар	21
4.1	Дулаан хангамжийн хяналт	10
4.2	Цахилгаан хангамжийн хяналт	11
6	Хүнс, хөдөө аж ахуйн салбар	311
6.1	Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний хяналт	62
6.2	Мал эмнэлгийн хяналт	122
6.3	Таримал ургамлын үр, сортын хяналт	6
6.4	Ургамал хамгааллын хяналт	22
6.5	Хүнсний чанар, стандартын хяналт	99

5	Зам, тээврийн салбар	72
5.1	Авто замын хяналт	18
5.2	Тээврийн хяналт	54
7	Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбар	37
7.1	Газрын тос, хийн хяналт	9
7.2	Геологи, уул уурхайн хяналт	24
7.3	Цөмийн болон цацрагийн хяналт	4
8	Байгаль орчны хяналт	136
9	Боловсролын хяналт	32
10	Газар, геодези, зураг зүйн хяналт	27
11	Мэдээлэл, харилцаа холбооны хяналт	19
12	Соёл, соёлын өв, аялал жуулчлалын хяналт	5
13	Хэмжил зүйн хяналт	23
14	Хилийн хорио, цээр	16
14.1	Мал эмнэлгийн хяналт	6
14.2	Стандарт /эм, био бэлдмэл, хүнс/-ийн хяналт	4
14.3	Ургамал, хорио цээрийн хяналт	2
14.4	Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналт	4
15	Сорилтын, нийслэлийн, хилийн лаборатори, ХАБҮЛЛ	-
16	Бусад	3
	НИЙТ	1006

2.2.Судалгааны үндсэн мэдээлэл


Мэргэжлийн хяналтын тогтолцооны өнөөгийн төлөв байдал, чиг хандлага, цаашид сайжруулах санал, байр суурийг тодорхойлох хэсгийн асуулга нь дараах асуулт болон хариултын сонголтоос бүрдэнэ. Үүнд:

Хүснэгт 2.

№	Асуулт	Хариултын тоо	Хариултын сонголт
1	Мэргэжлийн хяналтын чиг үүргийг тухайн салбарт нь шилжүүлснээр ямар үр дагавар/үр нөлөө бий болсон бэ?	9	1.1 Хяналт шалгалтыг салбарын бодлоготой уялдуулах боломжтой болсон.
			1.2 Төсөв, санхүүжилт сайжирсан
			1.3 Цалин хөлс нэмэгдсэн
			1.4 Ажиллах орчин, нөхцөл сайжирсан.
			1.5 Хяналт шалгалтын хараат бус байдал сайжирсан.
			1.6 Нэгдсэн бодлого, арга зүйтэй болсон.
			1.7 Хяналт шалгалтын давхардал арилсан.
			1.8 Хүний нөөцийн бодлого сайжирсан.
			1.9 Мэргэжлийн хяналтын нэр хүнд сайжирсан.
2	Мэргэжлийн хяналтын нэгдсэн тогтолцооны талаар Та ямар саналтай байна вэ?	4	2.1 Мэдэхгүй.
			2.2 Мэргэжлийн хяналтын байгууллагын нэгдсэн тогтолцоог дахин байгуулах хэрэгтэй.
			2.3 Салбарын хяналтын хэлбэрээр ажиллахад асуудалгүй.
			2.4 Саналгүй.
3		4	3.1 Хяналтын хараат бус байдлыг хангана.

Мэргэжлийн хяналтын чиг үүргийг тухайн салбарт нь шилжүүлснээр үүссэн үр дагаврыг үнэлсэн байдлыг хяналтын байцаагчдын ажилласан жилээр харуулж байна.

График 9. Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарт нь шилжүүлснээр бий болсон үр дагавар/үр нөлөөг үнэлсэн байдал, хяналтын байцаагчдын ажилласан хугацаагаар, хариултын тоогоор



Графикаас харахад мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын байгууллагуудад шилжүүлсэнтэй холбоотойгоор гарсан өөрчлөлтийг нийт байцаагчид харилцан адилгүй үнэлсэн байна.

Судалгаанд оролцсон хяналтын байцаагчдын ажилласан хугацаагаар ангилан авч үзэхэд мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын байгууллагуудад шилжүүлсэн өөрчлөлтийн үр нөлөөг үнэлэх үнэлгээ харилцан адилгүй байна. Ерөнхийдөө олон жил ажилласан байцаагчид өөрчлөлтийн үр нөлөөг илүү


бодитой, шүүмжлэлтэй үнэлэх хандлагатай байгаа бол харьцангуй бага хугацаанд ажилласан байцаагчдын дунд эерэг үнэлгээ давамгайлах хандлага ажиглагдсан.

Графикаас харахад ажилласан жилийн бүлгүүдийн дунд хариултын тооны хувьд ялгаа байгаа бөгөөд хамгийн олон хариулт өгсөн бүлгийн үнэлгээ нь нийт үр дүнгийн чиг хандлагад илүү их нөлөө үзүүлж байна. Түүнчлэн ажилласан хугацаа нэмэгдэхийн хэрээр чиг үүргийн шилжилтийн үр нөлөөг “дунд зэрэг” болон “сөрөг” гэж үнэлсэн хувь өсөх хандлага илэрч байгаа нь өмнөх тогтолцоо болон шинэ зохион байгуулалтын ялгааг илүү сайн мэдэрч байгаатай холбоотой байж болох юм.

Энэ нь мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын байгууллагуудад шилжүүлэх үйл явц нь хяналтын тогтолцоо, хүний нөөцийн зохион байгуулалт, ажлын уялдаа холбоонд тодорхой өөрчлөлт авчирсан бөгөөд эдгээр өөрчлөлтийн үр нөлөөг ажилтнуудын туршлага, ажилласан хугацаанаас хамааран өөр өөрөөр үнэлж байгааг харуулж байна.

Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарт нь шилжүүлснээр бий болсон үр дагавар/үр нөлөөг хариултын сонголт бүрээр харууллаа.

График 10. Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарт нь шилжүүлснээр “Хяналт шалгалтыг салбарын бодлоготой уялдуулах боломжтой болсон” хариулт, хувиар, салбараар




Судалгааны дүнгээс харахад мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын байгууллагуудад шилжүүлснээр хяналт шалгалтыг тухайн салбарын бодлоготой уялдуулах боломж нэмэгдсэн эсэх талаар оролцогчдын үнэлгээ харилцан адилгүй байна. Судалгаанд оролцогчдын 26.4 хувь нь уг өөрчлөлттэй санал нийлж, 29.6 хувь нь зарим талаар санал нийлсэн бол 43.9 хувь нь санал нийлэхгүй гэж хариулсан байна. Энэ нь нийт оролцогчдын дунд хяналт шалгалтыг салбарын бодлоготой илүү үр дүнтэй уялдуулах боломж бүрэн бүрдээгүй гэсэн хандлага давамгайлж байгааг харуулж байна.

Салбар тус бүрээр авч үзвэл мэдээлэл, харилцаа холбооны хяналт (47.4%), эрчим хүчний салбарын хяналт (47.6%), хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хяналт (37.3%), байгаль орчны хяналт (37.5%) зэрэг салбаруудад хяналт шалгалтыг бодлоготой уялдуулах боломж сайжирсан гэж үзсэн хувь харьцангуй өндөр байна. Түүнчлэн “Бусад” ангилалд хамрагдсан оролцогчдын 66.7 хувь нь уг өөрчлөлтийг эерэгээр үнэлжээ.

Харин хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар (72.3%), газар, геодези, зураг зүйн хяналт (63.0%), аж үйлдвэр, эрдэс баялгийн салбар (62.2%), барилга, хотын байгуулалтын салбар (52.2%), химийн хортой болон аюултай бодисын хяналт (50.0%), эрүүл мэндийн салбар (50.4%) зэрэгт оролцогчдын талаас илүү хувь нь санал нийлэхгүй гэж хариулсан нь чиг үүргийн шилжилт нь эдгээр салбаруудад хяналт шалгалтыг бодлоготой уялдуулах үр нөлөөг хангалттай бий болгож чадаагүй гэж үзэж байгааг илэрхийлж байна.

Ерөнхийдөө мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын байгууллагуудад шилжүүлсэн нь зарим салбарт бодлого, хяналтын уялдааг сайжруулах боломж бүрдүүлсэн гэж үнэлэгдэж байгаа боловч нийт дүнгээрээ оролцогчдын дунд эерэг үнэлгээ давамгайлаагүй бөгөөд салбар хоорондын ялгаа их байгаа нь энэхүү шинэчлэлийн үр нөлөө жигд бус байгааг харуулж байна.

График 11. Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарт нь шилжүүлснээр “Төсөв, санхүүжилт сайжирсан” хариулт, хувиар, салбараар



Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын байгууллагуудад шилжүүлснээр төсөв, санхүүжилт сайжирсан гэсэн хариулт нийт оролцогчдын дунд бага байна. Нийт хариултын 14.6 хувь нь төсөв санхүүжилт сайжирсан гэсэн хариулттай санал нийлж, 31.5 хувь нь зарим талаар санал нийлсэн бол 53.9 хувь нь санал нийлэхгүй гэж хариулжээ.


Энэ нь судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь чиг үүргийн шилжилтийн үр дүнд төсөв, санхүүжилтийн нөхцөл байдал сайжраагүй гэж үзэж байгааг харуулж байна.

Салбарын ангиллаар авч үзвэл химийн хортой болон аюултай бодисын хяналтын чиглэлийн байцаагчдын 62.5 хувь (12.5 хувь нь санал нийлж, 50.0 хувь нь зарим талаар санал нийлсэн), мэдээлэл, харилцаа холбооны хяналтын байцаагчдын 52.6 хувь, зам, тээврийн салбарын хяналтын байцаагчдын 59.7 хувь, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хяналтын байцаагчдын 56.6 хувь нь төсөв, санхүүжилтийн байдал тодорхой хэмжээнд сайжирсан гэж үнэлсэн байна.

Харин хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын (85.7%), соёл, соёлын өв, аялал жуулчлалын (80.0%), газар, геодези, зураг зүйн (77.8%), хэмжил зүйн (69.6%), боловсролын (65.6%), эрүүл мэндийн салбарын (59.0%) хяналтын байцаагчдын олонх нь санал нийлэхгүй гэж хариулсан нь төсөв, санхүүжилтийн нөхцөлд бодит ахиц гараагүй гэсэн үнэлгээ давамгайлж байгааг харуулж байна.

Эндээс үзэхэд мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын байгууллагуудад шилжүүлсэн нь төсөв, санхүүжилтийн нөхцөлийг сайжруулахад тодорхой салбаруудад эерэг өөрчлөлт авчирсан боловч нийт дүнгээрээ төсөв, санхүүжилт сайжирсан гэж үнэлэхээс илүүтэйгээр өмнөх түвшинд хадгалагдсан эсвэл дорвитой өөрчлөлт гараагүй гэж үзэж буй хандлага давамгайлж байна. Энэ нь чиг үүргийн шилжилт дангаараа санхүүгийн нөөцийн хүрэлцээ, хуваарилалтын асуудлыг шийдвэрлэхэд хангалтгүй байгааг илтгэж байна.

График 12. Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарт нь шилжүүлснээр “Цалин хөлс нэмэгдсэн” хариулт, хувиар, салбараар




Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын байгууллагуудад шилжүүлснээр цалин хөлс нэмэгдсэн гэсэн үр нөлөөг оролцогчдын дийлэнх нь сөргөөр үнэлсэн байна. Нийт оролцогчдын 21.3 хувь нь санал нийлж, 33.6 хувь нь зарим талаар санал нийлсэн бол 45.1 хувь нь санал нийлэхгүй гэж хариулжээ.

Салбарын ангиллаар авч үзвэл мэдээлэл, харилцаа холбооны хяналт (31.6 хувь нь санал нийлж, 47.4 хувь нь зарим талаар санал нийлсэн), зам, тээврийн салбарын хяналт (30.6 хувь, 43.1 хувь), аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын хяналт (32.4 хувь, 35.1 хувь), химийн хортой болон аюултай бодисын хяналт (25.0 хувь, 43.8 хувь), эрчим хүчний салбарын хяналт (42.9 хувь, 38.1 хувь) зэрэг салбарт цалин хөлсний нөхцөл тодорхой хэмжээнд сайжирсан гэж үзсэн хариулт харьцангуй өндөр байна. Ялангуяа, эрчим хүч, мэдээлэл харилцаа холбоо, зам тээвэр, аж үйлдвэр, эрдэс баялгийн салбаруудад санал нийлсэн болон зарим талаар санал нийлсэн хариултын нийлбэр 65–80 хувьд хүрч байгаа нь эдгээр салбарт эерэг өөрчлөлт илүү мэдрэгдсэнийг харуулж байна.

Харин хэмжил зүйн хяналт (78.3 хувь), хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хяналт (71.4 хувь), газар, геодези, зураг зүйн хяналт (55.6 хувь), боловсролын хяналт (53.1 хувь), барилга, хот байгуулалтын салбарын хяналт (47.8 хувь), эрүүл мэндийн салбарын хяналт (45.3 хувь) зэрэг салбаруудад санал нийлэхгүй гэсэн хариулт давамгайлсан байна.

Мэргэжлийн хяналтын чиг үүргийг тухайн салбарт шилжүүлсэн нь зарим салбарын хувьд цалин хөлсний нөхцөлд эерэг өөрчлөлт авчирсан боловч нийт дүнгээрээ оролцогчдын дунд сөрөг үнэлгээ давамгайл байна.

График 13. Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарт нь шилжүүлснээр “Ажиллах орчин, нөхцөл сайжирсан” хариулт, хувиар, салбараар




Судалгааны дүнгээс харахад нийт оролцогчдын 18.6 хувь нь мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын байгууллагад шилжүүлснээр ажиллах орчин, нөхцөл сайжирсан гэж, 32.4 хувь нь зарим талаар сайжирсан гэж үзсэн бол 49.0 хувь нь энэ үзүүлэлттэй санал нийлэхгүй гэж хариулжээ. Өөрөөр хэлбэл, нийт оролцогчдын тал орчим нь ажиллах орчин, нөхцөлд бодит ахиц гараагүй гэж үнэлсэн байна.

Салбараар харвал, зам, тээврийн салбар (72.2 хувь), хилийн хорио цээр (68.8 хувь), мэдээлэл, харилцаа холбооны салбар (68.4 хувь), хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар (62.1 хувь), аж үйлдвэр, эрдэс баялгийн салбар (59.4 хувь)-ын оролцогчид ажиллах орчин, нөхцөл тодорхой хэмжээгээр сайжирсан гэж үнэлсэн байна.

Харин соёл, соёлын өв, аялал жуулчлалын (80.0 хувь), хөдөлмөр, нийгмийн хамгааллын (73.1 хувь), боловсролын (65.6 хувь), эрүүл мэндийн (64.0 хувь), газар, геодези, зураг зүйн (63.0 хувь) салбараас судалгаанд оролцогчдын дийлэнх нь ажиллах орчин, нөхцөл сайжраагүй гэж үнэлжээ.

Эндээс ажиллах орчин, нөхцөлд гарсан өөрчлөлтийн үнэлгээ салбар хооронд мэдэгдэхүйц ялгаатай байгаа бөгөөд чиг үүрэг шилжүүлсний эерэг нөлөө бүх салбарт жигд илрээгүй байна. Ялангуяа, нийгмийн болон боловсрол, эрүүл мэнд зэрэг салбарт ажиллах орчин сайжраагүй гэсэн хариулт өндөр хувьтай байгаа нь хүний нөөц, ажлын байрны орчин, техник, тоног төхөөрөмж болон байгууллагын дотоод зохион байгуулалтыг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

График 14.Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарт нь шилжүүлснээр “Хяналт шалгалтын хараат бус байдал сайжирсан” хариулт, хувиар, салбараар




Нийт оролцогчдын 17.0 хувь нь мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын байгууллагад шилжүүлснээр хяналт шалгалтын хараат бус байдал сайжирсан гэж, 26.4 хувь нь зарим талаар сайжирсан гэж үзсэн бол 56.6 хувь нь энэ үзүүлэлттэй санал нийлэхгүй гэж хариулжээ. Энэ нь оролцогчдын талаас илүү хувь нь чиг үүрэг шилжүүлсний дараа хяналт шалгалтын хараат бус байдал бодитоор сайжраагүй гэж үзэж байгааг харуулж байна.

Салбарын ялгаагаар авч үзвэл, хилийн хорио цээрийн хяналт хамгийн өндөр эерэг үнэлгээтэй байгаа бөгөөд оролцогчдын 62.6 хувь (6.3 хувь нь "санал нийлнэ", 56.3 хувь нь "зарим талаар санал нийлнэ") нь хараат бус байдал сайжирсан гэж үнэлжээ. Мөн хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар (56.9 хувь), зам, тээврийн салбар (58.3 хувь), байгаль орчны хяналт (50.8 хувь)-ын оролцогчдын талаас илүү хувь нь тодорхой хэмжээнд эерэг өөрчлөлт гарсан гэж үзсэн байна.

Харин соёл, соёлын өв, аялал жуулчлалын хяналт (100.0 хувь), аж үйлдвэр, эрдэс баялгийн салбар (86.5 хувь), хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар (78.2 хувь), газар, геодези, зураг зүйн хяналт (77.8 хувь), боловсролын хяналт (68.8 хувь), хэмжил зүйн хяналт (65.2 хувь), барилга, хотын байгуулалтын салбар (65.2 хувь), эрүүл мэндийн салбар (64.7 хувь)-ын оролцогчдын дийлэнх нь хараат бус байдал сайжраагүй гэж үнэлжээ.

Судалгаанд оролцогчдын үнэлгээгээр хяналт шалгалтын хараат бус байдлыг сайжруулах зорилгоор чиг үүргийг салбарын байгууллагад шилжүүлсэн арга хэмжээний үр нөлөө хангалтгүй байна. Хэдийгээр зарим салбарт эерэг өөрчлөлт ажиглагдсан боловч нийт дүнгээр сөрөг үнэлгээ давамгайлж байна.

График 15. Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарт нь шилжүүлснээр “Нэгдсэн бодлого, арга зүйтэй болсон” хариулт, хувиар, салбараар




Судалгаанд оролцогчдын 17.0 хувь нь мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын байгууллагад шилжүүлснээр хяналт шалгалтын хараат бус байдал сайжирсан гэж, 26.4 хувь нь зарим талаар сайжирсан гэж үзсэн бол 56.6 хувь нь энэ үзүүлэлттэй санал нийлэхгүй гэж хариулжээ.

Үүнээс хилийн хорио цээрийн хяналт хамгийн өндөр эерэг үнэлгээтэй байгаа бөгөөд оролцогчдын 62.6 хувь (6.3 хувь нь "санал нийлнэ", 56.3 хувь нь "зарим талаар санал нийлнэ") нь хараат бус байдал сайжирсан гэж үнэлжээ. Мөн хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар (56.9 хувь), зам, тээврийн салбар (58.3 хувь), байгаль орчны хяналт (50.8 хувь)-ын салбараас оролцогчдын талаас илүү хувь нь тодорхой хэмжээнд эерэг өөрчлөлт гарсан гэж үзсэн байна.

Харин соёл, соёлын өв, аялал жуулчлалын хяналт (100.0 хувь), аж үйлдвэр, эрдэс баялгийн салбар (86.5 хувь), хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар (78.2 хувь), газар, геодези, зураг зүйн хяналт (77.8 хувь), боловсролын хяналт (68.8 хувь), хэмжил зүйн хяналт (65.2 хувь), барилга, хотын байгуулалтын салбар (65.2 хувь), эрүүл мэндийн салбар (64.7 хувь)-ын оролцогчдын дийлэнх нь хараат бус байдал сайжраагүй гэж үнэлжээ.

Дээрх мэдээлээс харахад хяналт шалгалтын хараат бус байдлыг сайжруулах зорилгоор чиг үүргийг салбарын байгууллагад шилжүүлсэн арга хэмжээний үр нөлөө оролцогчдын үнэлгээгээр хангалтгүй байна.

График 16.Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарт нь шилжүүлснээр “Хяналт шалгалтын давхардал багассан” хариулт, хувиар, салбараар




Нийт оролцогчдын 17.7 хувь нь мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын байгууллагад шилжүүлснээр хяналт шалгалтын давхардал багассан, 20.1 хувь нь зарим талаар багассан гэж үзсэн бол 62.2 хувь нь багасаагүй буюу нийт оролцогчдын бараг гуравны хоёр нь хяналт шалгалтын давхардал буураагүй гэж үзжээ.

Салбараар харвал, зам, тээврийн салбар (56.9 хувь), хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар (51.2 хувь), хилийн хорио цээрийн хяналт (50.1 хувь), эрчим хүчний салбар (42.9 хувь), байгаль орчны хяналт (47.1 хувь), барилга, хот байгуулалтын салбар (41.3 хувь)-ын оролцогчид хяналт шалгалтын давхардал тодорхой хэмжээгээр буурсан гэж үнэлсэн байна.

Харин соёл, соёлын өв, аялал жуулчлалын хяналт (100.0 хувь), аж үйлдвэр, эрдэс баялгийн салбар (86.5 хувь), хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар (85.7 хувь), боловсролын хяналт (84.4 хувь), хэмжил зүйн хяналт (82.6 хувь), газар, геодези, зураг зүйн хяналт (77.8 хувь), эрүүл мэндийн салбар (75.5 хувь)-ын оролцогчдын дийлэнх нь хяналт шалгалтын давхардал багасаагүй гэж үнэлжээ.

Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын байгууллагад шилжүүлсэн нь хяналт шалгалтын давхардлыг бууруулах зорилгод нийтлэг хэмжээнд хүрээгүй гэж үзсэн байна.

График 17. Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарт нь шилжүүлснээр “Хүний нөөцийн бодлого сайжирсан” хариулт, хувиар, салбараар




Судалгаанд оролцогчдын 15.5 хувь нь мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын байгууллагад шилжүүлснээр хүний нөөцийн бодлого сайжирсан, 26.0 хувь нь зарим талаар сайжирсан гэж үзсэн бол 58.4 хувь нь сайжраагүй гэж хариулжээ. Энэ нь оролцогчдын талаас илүү хувь нь чиг үүрэг шилжүүлсний дараа хүний нөөцийн бодлогод дорвитой ахиц гараагүй гэж үнэлснийг харуулж байна.

Үүнээс эрчим хүчний салбар (52.4 хувь), хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар (53.7 хувь), хилийн хорио цээрийн хяналт (56.3 хувь), мэдээлэл, харилцаа холбооны хяналт (52.6 хувь), зам, тээврийн салбар (57.0 хувь)-ын оролцогчид хүний нөөцийн бодлогод тодорхой хэмжээнд эерэг өөрчлөлт гарсан гэж үнэлжээ.

Харин соёл, соёлын өв, аялал жуулчлалын хяналт (100.0 хувь), хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар (84.0 хувь), газар, геодези, зураг зүйн хяналт (77.8 хувь), аж үйлдвэр, эрдэс баялгийн салбар (70.3 хувь), хэмжил зүйн хяналт (69.6 хувь), эрүүл мэндийн салбар (69.1 хувь), боловсролын хяналт (68.8 хувь), барилга, хот байгуулалтын салбар (63.0 хувь)-ын оролцогчдын дийлэнх нь хүний нөөцийн бодлого сайжраагүй гэж үнэлсэн байна.

Судалгааны үр дүнгээс харахад чиг үүргийг салбарын байгууллагад шилжүүлсэн нь хүний нөөцийн бодлого үр дүнд хүрээгүй гэж үнэлсэн байна.

График 18.Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарт нь шилжүүлснээр “Мэргэжлийн хяналтын нэр хүнд сайжирсан” хариулт, хувиар, салбараар



Судалгаанд оролцогчдын 15.9 хувь нь мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын байгууллагад шилжүүлснээр мэргэжлийн хяналтын нэр хүнд сайжирсан, 21.6 хувь нь зарим талаар сайжирсан гэж үзсэн бол 62.5 хувь нь энэ үзүүлэлттэй санал нийлэхгүй гэж хариулжээ. Энэ нь нийт оролцогчдын бараг гуравны хоёр нь чиг үүрэг шилжүүлсний дараа мэргэжлийн хяналтын байгууллагын нэр хүндэд эерэг өөрчлөлт гараагүй гэж үнэлснийг харуулж байна.

Энэ үзүүлэлтийг салбараар харвал, зам, тээврийн салбар (58.3 хувь), мэдээлэл, харилцаа холбооны хяналт (52.6 хувь), эрчим хүчний салбар (42.9 хувь), байгаль орчны хяналт (49.3 хувь), хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар (48.6 хувь)-т ажиллагчид мэргэжлийн хяналтын нэр хүнд тодорхой хэмжээнд сайжирсан гэж үнэлсэн байна.


Харин хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар (85.7 хувь), боловсролын хяналт (84.4 хувь), аж үйлдвэр, эрдэс баялгийн салбар (83.8 хувь), соёл, соёлын өв, аялал жуулчлалын хяналт (80.0 хувь), газар, геодези, зураг зүйн хяналт (77.8 хувь), эрүүл мэндийн салбар (76.3 хувь), хэмжил зүйн хяналт (73.9 хувь), барилга, хот байгуулалтын салбар (65.2 хувь), хилийн хорио цээрийн салбар (62.5 хувь)-ын оролцогчдын дийлэнх нь мэргэжлийн хяналтын нэр хүнд сайжраагүй гэж үнэлжээ.

Дээрх мэдээллээс харахад мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын байгууллагад шилжүүлсэн нь байгууллагын нэр хүндийг дээшлүүлэхэд эерэг үр дүн авчраагүй болохыг харуулж байна.

Мэргэжлийн хяналтын нэгдсэн тогтолцооны талаарх үзэл бодол

Мэргэжлийн хяналтын нэгдсэн тогтолцооны талаарх үзэл бодлыг судалгааны хүрээнд тандан судаллаа. Асуултад хариулсан байдлыг ажилладаг байгууллага болон хяналтын чиглэлээр авч үзэв.

График 19. Мэргэжлийн хяналтын нэгдсэн тогтолцооны талаар хариулсан байдал, байгууллагаар



Судалгаанд оролцогчдоос мэргэжлийн хяналтын байгууллагын нэгдсэн тогтолцоог дахин байгуулах шаардлагатай эсэх талаар тодруулахад оролцогчдын 73.2 хувь нь дахин байгуулах шаардлагатай гэж, 20.1 хувь нь салбарын хяналтын хэлбэрээр ажиллахад асуудалгүй гэж, 4.5 хувь нь мэдэхгүй, 2.3 хувь нь саналгүй гэж хариулсан байна. Энэ нь нийт оролцогчдын дийлэнх нь мэргэжлийн хяналтын байгууллагын нэгдсэн тогтолцоог сэргээн байгуулах шаардлагатай гэж үзэж байгааг харуулж байна.

Байгууллагын төрлөөр авч үзвэл, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын оролцогчдын 86.7 хувь, Засаг даргын дэргэдэх агентлагийн 82.1 хувь, агентлагийн аймаг, нийслэлийн газар, хэлтсийн 78.0 хувь, агентлагийн сум, дүүргийн нэгжийн 76.9 хувь, төрийн захиргааны байгууллага (агентлаг)-ийн 71.4 хувь, яамны 61.7 хувь нь мэргэжлийн хяналтын байгууллагын нэгдсэн тогтолцоог дахин байгуулах шаардлагатай гэж үзжээ.


Харин салбарын хяналтын тогтолцоог хэвээр үргэлжлүүлэхэд асуудалгүй гэсэн байр суурь яамны оролцогчдын дунд харьцангуй өндөр (36.7 хувь) байсан бол төрийн захиргааны байгууллага (21.4 хувь), сум, дүүргийн Засаг даргын

Тамгын газар (24.0 хувь), агентлагийн сум, дүүргийн нэгж (19.2 хувь), агентлагийн аймаг, нийслэлийн газар, хэлтэс (18.3 хувь) зэрэг байгууллагуудад энэ үзүүлэлт 18–24 хувь байна.

Мөн сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын оролцогчдын 13.0 хувь нь "мэдэхгүй" гэж хариулсан нь бусад байгууллагуудтай харьцуулахад хамгийн өндөр байгаа бол "саналгүй" гэсэн хариулт Бусад ангилалд (9.5 хувь) болон сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар (5.5 хувь)-т харьцангуй өндөр байна.

Ерөнхийд нь авч үзвэл, байгууллагын төрлөөс үл хамааран оролцогчдын олонх нь мэргэжлийн хяналтын байгууллагын нэгдсэн тогтолцоог дахин байгуулах шаардлагатай гэсэн байр суурьтай байна. Ялангуяа, орон нутгийн байгууллагууд болон Засаг даргын дэргэдэх агентлагуудад энэ байр суурь илүү илэрч байгаа нь мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбаруудад шилжүүлсний дараах зохион байгуулалт, уялдаа холбоо, нэгдсэн удирдлагын тогтолцоонд тулгарч буй хүндрэл, хэрэгцээг илэрхийлж байна. Харин яамны түвшинд салбарын хяналтын тогтолцоог үргэлжлүүлэх боломжтой гэж үзсэн оролцогчдын хувь харьцангуй өндөр байгаа нь төв болон орон нутгийн байгууллагуудын асуудлыг үнэлэх хандлагад тодорхой ялгаа байгааг харуулж байна.

График 20. Мэргэжлийн хяналтын нэгдсэн тогтолцооны талаар хариулсан байдал, хяналтын чиглэлээр, тоогоор



Дээрх асуултын хариултыг судалгаанд оролцогчдын ажилладаг салбар, хяналтын чиглэлээр харвал, соёл, соёлын өв, аялал жуулчлалын хяналт (100.0 хувь), хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар (95.0 хувь), боловсролын хяналт (90.6 хувь), аж үйлдвэр, эрдэс баялгийн салбар (89.2 хувь), барилга, хот байгуулалтын салбар (84.8 хувь), эрүүл мэндийн салбар (82.0 хувь), газар, геодези, зураг зүйн хяналт (81.5 хувь), хилийн хорио цээрийн хяналт (81.3 хувь), хэмжил зүйн хяналт (73.9 хувь), мэдээлэл, харилцаа холбооны хяналт (73.7 хувь),

байгаль орчны хяналт (70.6 хувь)-ын оролцогчдын олонх нь нэгдсэн тогтолцоог дахин байгуулах шаардлагатай гэж үзжээ.

Харин эрчим хүчний салбар (57.1 хувь), хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар (57.9 хувь), зам, тээврийн салбар (65.3 хувь)-ын оролцогчдын дунд нэгдсэн тогтолцоог дахин байгуулахыг дэмжсэн хувь бусад салбартай харьцуулахад харьцангуй бага байна.


Нөгөө талаас, салбарын хяналтын хэлбэрээр үргэлжлүүлэн ажиллахад асуудалгүй гэсэн байр суурь эрчим хүчний салбарт хамгийн өндөр (38.1 хувь) байсан бөгөөд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар (31.5 хувь), мэдээлэл, харилцаа холбооны хяналт (26.3 хувь), зам, тээврийн салбар (26.4 хувь), байгаль орчны хяналт (22.8 хувь)-д харьцангуй өндөр байна.

Ерөнхийд нь авч үзвэл, бараг бүх салбарын оролцогчид мэргэжлийн хяналтын байгууллагын нэгдсэн тогтолцоог дахин байгуулах шаардлагатай гэсэн байр суурийг давамгайл байна.

Мэргэжлийн хяналтын байгууллагын нэгдсэн тогтолцоог дахин байгуулахыг дэмжсэн байр суурь нь нийтлэгээр дийлэнх хувийг эзэлж байна.

Судалгаанд оролцогчдын мэргэжлийн хяналтын нэгдсэн тогтолцооны талаарх байр суурийг нэгтгэн харуулж байна.


График 21. Мэргэжлийн хяналтын нэгдсэн тогтолцооны талаарх судалгаанд оролцогчдын байр суурь, хувиар



Судалгаанд оролцсон салбарын байцаагчдын 1/5 хувь буюу 20 хувь нь хяналтыг цаашид салбарын хяналтын хэлбэрээр үргэлжлүүлэхэд асуудалгүй гэж хариулсан бол дийлэнх олонх буюу 73 хувь нь хяналтыг цаашид төвлөрүүлэх буюу нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай гэж үзсэн байна.

Дээрх асуултад хариулсан байдлыг байцаагчдын ажилласан жил, хугацаагаар мөн авч үзэв.

График 22.Мэргэжлийн хяналтын нэгдсэн тогтолцооны талаар хариулсан байдал, хяналтын байцаагчдын ажилласан хугацаагаар, хувиар



Графикаас харахад судалгаанд оролцсон байцаагчдын дийлэнх нь мэргэжлийн хяналтын байгууллагыг дахин байгуулахыг дэмжиж байгаа бөгөөд нийт оролцогчдын 73.2 хувь нь энэ байр суурийг илэрхийлжээ. Харин 20.1 хувь нь салбарын хяналтын тогтолцоог хэвээр хадгалах нь зүйтэй гэж үзсэн бол 2.3 хувь нь саналгүй, 4.5 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.

Түүнчлэн ажилласан жил нэмэгдэхийн хэрээр мэргэжлийн хяналтын байгууллагыг дахин байгуулахыг дэмжсэн байр суурь өсөх хандлагатай байна. Тухайлбал, 1 жил хүртэлх ажилласан байцаагчдын 62.5 хувь энэ саналыг дэмжсэн бол 20 болон түүнээс дээш жил ажилласан байцаагчдын дунд уг үзүүлэлт 82.5 хувь болж хамгийн өндөр байна. Харин 1–3 жил (64.7 хувь), 4–9 жил (70.7 хувь), 10–14 жил (76.5 хувь), 15–19 жил (79.9 хувь) ажилласан бүлгүүдэд мөн энэ хандлага адил байгааг график харуулж байна.

Нөгөө талаас, салбарын хяналтын тогтолцоог хэвээр хадгалах байр суурь харьцангуй бага буюу 20–24.3 хувийн хооронд хэлбэлзэж байна. Ялангуяа, 1–3 жил ажилласан байцаагчдын хувьд энэ үзүүлэлт 24.3 хувь байсан бол 20 ба түүнээс дээш жил ажилласан байцаагчдын дунд 13.5 хувь болж хамгийн бага үзүүлэлттэй байна.

Ийнхүү судалгааны үр дүнгээс харахад бүх ажилласан жилийн бүлэгт мэргэжлийн хяналтын байгууллагыг дахин байгуулахыг дэмжих санал давамгай байгаа бөгөөд энэ хандлага нь туршлага, ажилласан жил нэмэгдэхийн хэрээр илүү хүчтэй илэрч байна.

Мэргэжлийн хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлснээр гарах үр дүнгийн талаарх үзэл бодол

Мэргэжлийн хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлснээр ямар үр дүн гарах талаарх үзэл бодлыг тандан судаллаа.

График 23. Мэргэжлийн хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлснээр гарах үр дүнгийн талаарх хариулт, хувиар




Судалгаанд оролцсон байцаагчдын дийлэнх нь мэргэжлийн хяналтын байгууллагыг дахин байгуулснаар хяналт шалгалтын тогтолцооны үр нөлөө сайжирна гэж үзсэн байна. Үзүүлэлт тус бүрээр авч үзэхэд оролцогчдын 87–89 хувь нь санал нийлсэн бол 6–7 хувь нь зарим талаар санал нийлсэн, 1 хувиас бага нь санал нийлэхгүй гэж хариулжээ.

“Нэгдсэн удирдлага, зохицуулалт сайжирна” гэсэнтэй 682 хүн (89.1 хувь) санал нийлж, 47 хүн (6.1 хувь) зарим талаар санал нийлсэн, 7 хүн (0.9 хувь) санал нийлэхгүй гэж хариулсан байна. “Хяналтын үр нөлөө, хариуцлага сайжирна” гэсэн үзүүлэлтэд 681 хүн (88.9 хувь) санал нийлсэн бөгөөд санал нийлэхгүй гэж үзсэн оролцогч хамгийн бага буюу 7 хүн (0.9 хувь) байв.

Мөн “Хяналт шалгалтын давхардал буурна” гэсэн үзүүлэлтийг 678 хүн (88.5 хувь) дэмжсэн бол 47 хүн (6.1 хувь) зарим талаар санал нийлж, 11 хүн (1.4 хувь) санал нийлэхгүй гэж хариулсан байна. Харин “Хяналтын хараат бус байдал хангагдана” гэсэн үзүүлэлт бусадтай харьцуулахад харьцангуй бага хэдий ч 672 хүн (87.8 хувь) санал нийлнэ, 55 хүн (7.2 хувь) зарим талаар санал нийлнэ, 9 хүн (1.2 хувь) санал нийлэхгүй гэжээ.

Ерөнхийд нь авч үзвэл, судалгаанд оролцсон байцаагчид мэргэжлийн хяналтын байгууллагыг дахин байгуулснаар нэгдсэн удирдлага, зохицуулалт сайжрах, хяналтын үр нөлөө, хариуцлага дээшлэх, хяналт шалгалтын давхардал буурах, хараат бус байдал хангагдах зэрэг эерэг үр нөлөө гарна гэсэн нийтлэг байр суурьтай байгаа нь судалгааны үр дүнгээр харагдаж байна.

График 24. Мэргэжлийн хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлснээр гарах үр дүнгийн талаарх үзэл бодол, ажилласан хугацаа, хувиар



Мэргэжлийн хяналтын байгууллагыг дахин байгуулснаар гарах эерэг үр дүн гарна гэсэн үзэл бодол ажилласан жилийн бүх бүлэгт өндөр байна.

Тухайлбал, “Хяналт шалгалтын давхардал буурна” гэсэн үзүүлэлтэд санал нийлсэн оролцогчдын 24.5 хувь нь 4–9 жил, 19.5 хувь нь 20 болон түүнээс дээш жил, 16.5 хувь нь 15–19 жил ажилласан байцаагчид байсан бол 1 жил хүртэлх ажилласан байцаагчид 4.7 хувь байна.

“Хяналтын үр нөлөө, хариуцлага сайжирна” гэсэн үзүүлэлтэд санал нийлсэн оролцогчдын 24.8 хувь нь 4–9 жил, 19.5 хувь нь 20 болон түүнээс дээш жил, 16.6 хувь нь 15–19 жил ажилласан байцаагчид байсан бол “Нэгдсэн удирдлага, зохицуулалт сайжирна” гэсэн үзүүлэлтэд мөн адил 4–9 жил ажилласан бүлэг (24.3 хувь) хамгийн өндөр хувийг эзэлжээ.

Харин “Хяналтын хараат бус байдал хангагдана” гэсэн үзүүлэлтэд санал нийлсэн оролцогчдын 24.1 хувь нь 4–9 жил, 19.6 хувь нь 20 болон түүнээс дээш жил, 16.7 хувь нь 15–19 жил ажилласан байцаагчид байсан бөгөөд энэ нь бусад үзүүлэлтүүдтэй төстэй бүтэцтэй байна.


Нөгөө талаас, дөрвөн үзүүлэлт тус бүрээр санал нийлэхгүй гэж хариулсан оролцогчдын дунд 1–3 жил болон 4–9 жил ажилласан байцаагчдын эзлэх хувь харьцангуй өндөр байгаа боловч эдгээр хариултын нийт тоо маш бага тул нийт үнэлгээнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхгүй байна. Мөн дунд зэрэг буюу "зарим талаар санал нийлнэ" гэсэн хариултын бүтэц нь нийт судалгаанд оролцогчдын ажилласан жилийн бүтэцтэй ерөнхийдөө ижил тархалттай байна.

Ерөнхийдөө, мэргэжлийн хяналтын байгууллагыг дахин байгуулснаар гарах үр нөлөөний талаарх эерэг үнэлгээ нь бүх ажилласан жилийн бүлэгт давамгайл байгаа бөгөөд 4 ба түүнээс дээш жил ажилласан байцаагчдын дунд илүү байна. Энэ нь ажлын туршлага хуримтлуулсан байцаагчид нэгдсэн мэргэжлийн хяналтын тогтолцооны давуу талыг илүү үнэлэх хандлагатай байгааг харуулж байна.

Салбарын хяналт хэлбэрээр ажиллуулах талаарх үзэл бодол

Салбарын хяналтын хэлбэрээр ажиллуулахыг судалгаанд оролцсон 202 байцаагч дэмжсэн бөгөөд тэднээс дэмжсэн шалтгааныг нь тандах асуултыг судалгаанд оруулсан юм.

График 25. Салбарын хяналтын хэлбэрээр ажиллуулахыг дэмжсэн шалтгааныг тодорхойлсон байдал, нэгтгэл, тоогоор



Салбарын хяналтын тогтолцоог хэвээр хадгалахыг дэмжсэн байцаагчдын дунд 4–9 жил, 1–3 жил ажилласан албан хаагчдын эзлэх хувь харьцангуй өндөр байна.

Тухайлбал, “Одоогийн тогтолцоо хангалттай үр дүнтэй” гэсэн байр суурийг дэмжсэн оролцогчдын 27.9 хувь нь 4–9 жил, 25.0 хувь нь 1–3 жил, 14.9 хувь нь 10–14 жил, 11.4 хувь нь 15–19 жил, 11.4 хувь нь 20 болон түүнээс дээш жил, 6.4 хувь нь 1 жил хүртэлх ажилласан байцаагчид байна.

Мөн “Нэмэлт бүтэц, зардал шаардлагагүй” гэсэн үзүүлэлтэд санал нийлсэн оролцогчдын 29.7 хувь нь 4–9 жил, 23.4 хувь нь 1–3 жил, 16.6 хувь нь 10–14 жил ажилласан байцаагчид байсан бол “Шийдвэр гаргалт шуурхай” гэсэн үзүүлэлтэд 4–9 жил ажилласан бүлэг 28.8 хувь, 1–3 жил ажилласан бүлэг 23.5 хувь-ийг эзэлжээ.

“Хяналтыг салбарын бодлоготой уялдуулах боломж илүү” гэсэн үзүүлэлтийг дэмжсэн оролцогчдын 29.8 хувь нь 4–9 жил, 24.2 хувь нь 1–3 жил, 16.1 хувь нь 10–14 жил ажилласан байцаагчид байна.

Ерөнхийд нь авч үзвэл, салбарын хяналтын тогтолцоог хэвээр хадгалахыг дэмжсэн байцаагчдын дунд 4–9 жил болон 1–3 жил ажилласан албан хаагчид харьцангуй өндөр хувийг эзэлж байна.

2.3.Хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох талаарх санал

Судалгаанд хамрагдсан байцаагчдаас хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох талаарх саналыг асуусан. Оролцогчдоос нийт 620 санал ирснийг нэгтгэн танилцуулж байна.

Хүснэгт 3.Хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох санал, дүнд эзлэх хувиар

№	Санал	Саналын тоо	Нийт дүнд эзлэх хувь
	Нийт	620	100%
1	Хяналтын нэгдсэн тогтолцоог сэргээх, нэгдсэн удирдлагатай байх	202	32.6
2	Хяналт шалгалт хөндлөнгийн хараат бус, бие даасан бүтэцтэй байх	97	15.6
3	Мэргэжлийн хяналтын байгууллагыг дахин байгуулах	51	8.2
4	Улсын байцаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах	43	6.9
5	Хяналт шалгалтын давхардлыг бууруулах, арилгах	36	5.8
6	Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох	32	5.2
7	Улсын байцаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх	20	3.2
8	Салбарын хяналтын бүтэц, зохион байгуулалтаар ажиллуулах	18	2.9
9	Цахимжилт, хяналт шалгалтын мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэх	17	2.7
10	Бүтэц зохион байгуулалтын оновчтой, шинэ хувилбар боловсруулах	15	2.4
11	Хяналт шалгалтын үр дүнг сайжруулах, үр нөлөөг нэмэгдүүлэх	11	1.8
12	Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, нэгдсэн бодлого, аргачлалтай байх	10	1.6
13	Зарим хяналтыг нэгтгэх. (Үүнд: Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд эрсдэл учруулах хяналтын чиглэл)	10	1.6
14	Урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх хяналтын хэлбэрийг хэрэгжүүлэх	10	1.6
15	Хяналт шалгалтын төлөвлөлтийг сайжруулах, нэг ААНБ-д олон хяналт давхар очихгүй байх	9	1.5
16	Салбарын хяналтуудын хоорондын уялдааг сайжруулах	6	1.0
17	Зарим хяналтыг Мэргэжлийн холбоодод шилжүүлэх	4	0.6
18	Бусад	21	3.4
19	Саналгүй	8	1.3

Судалгааны үр дүнгээс харахад Улсын /ахлах/ байцаагчдын дийлэнх олонх нь:

- Хяналтын нэгдсэн тогтолцоог сэргээх шаардлагатай гэж 202 буюу 32.6 хувь нь,
- Хяналт шалгалтын байгууллагын хараат бус, бие даасан бүтэц чухал гэж 97 буюу 15.6 хувь нь,
- Мэргэжлийн хяналтын байгууллагыг дахин байгуулах гэж 51 буюу 8.2 хувь нь хариулсан байна.

Үүнээс дүгнэхэд нийт саналын 56.5 хувь нь Хяналт шалгалтын нэгдсэн, хараат бус, бие даасан тогтолцоотой байх, Мэргэжлийн хяналтын байгууллагыг дахин байгуулах гэж үзжээ.

Харин улсын байцаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа, мэргэжлийн ур чадварыг сайжруулах гэж 53 буюу 10 хувь нь, хяналт шалгалтын давхардлыг бууруулах, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох гэж 68 буюу 11 хувь нь үзсэн байгаа нь тогтолцооны үр ашигт сөргөөр нөлөөлөх тулгамдсан асуудал болж байна.

Одоогийн салбарын хяналтын бүтэц, зохион байгуулалтаар ажиллуулах гэж 18 буюу 2.9 хувь нь үзсэн байгаа нь салбар тус бүрийн хяналтын тогтолцоо нь тийм ч оновчтой биш, хоорондын уялдаа сул, хяналт шалгалтын стандарт, арга зүй харилцан адилгүй, хяналт шалгалт ар араасаа цуварч очиж байгаа нь иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад хүндрэл учруулж байгааг илтгэж байна.

2.4.Бүлгийн дүгнэлт

Хяналт шалгалтын чиг үүргийг салбарт хамааруулсан нь бодит, эерэг үр дүн, үр нөлөө бий болгоогүй гэдэгт хяналтын байцаагч нар анхан, дунд бүх шатлал, хяналтын чиглэл, ажлын туршлага, ажилласан хугацаанаас үл хамааран нийтлэгээр санал нэгдэж байна.

Хяналт шалгалтын нэгдсэн тогтолцоог сэргээн бүрдүүлснээр хяналт шалгалтын нэгдсэн арга зүй, төлөвлөлт, зохион байгуулалт сайжирч, хяналт шалгалтын давхардал буурснаар иргэд, хуулийн этгээдэд учрах чирэгдэл хүндрэл багасах, төрд итгэх олон нийтийн итгэл дээшлэх зэрэг олон талын ач холбогдол, эерэг нөлөөлөл хүлээгдэж байна.

Хяналт шалгалтын нэгдсэн, хараат бус, бие даасан тогтолцоог дахин бий болгож, эрх зүйн орчныг шинэчлэх, байцаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, хяналт шалгалтын цахим системийг шинэчлэн хөгжүүлж, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Дүгнэлтийг тоймловол:

Хяналтын нэгдсэн тогтолцоог сэргээх шаардлагатай: Салбаруудын хяналтыг нэгдсэн бодлого, удирдлага, арга зүйгээр хангаж, улсын хэмжээнд хяналт шалгалтын нэг стандартаар хэрэгжүүлэх шаардлагатай.

Хяналт шалгалтын байгууллага бие даасан бүтэцтэй, хараат бус байдлыг хангах шаардлагатай: Хяналт шалгалтын байгууллага нь салбарын ашиг сонирхлоос ангид, хөндлөнгийн нөлөөнд автахгүй, шийдвэр гаргах бие даасан эрхтэй байх шаардлагатай.

Мэргэжлийн хяналтын байгууллагыг дахин байгуулах хэрэгцээ шаардлага байна: Нэгдсэн тогтолцоо татан буугдсанаас мэргэжлийн хяналтын хоосон орон зай бий болж, хяналт шалгалт суларснаар хөдөлмөрийн аюулгүй байдал алдагдах, хүний амь нас хохирох эрсдэлүүд гарах нөхцөл бүрдсэн.

Улсын байцаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах шаардлагатай байна: Байцаагчдын ажиллах орчин, нийгмийн баталгааг сайжруулснаар тогтвортой ажиллах, мэргэжлийн ур чадвар хуримтлуулахыг дэмжих, улмаар чадварлаг хүний нөөц нь хяналт шалгалтын чанар, үр дүнд шууд нөлөө үзүүлнэ.

Хууль, эрх зүйн орчныг шинэчлэх шаардлагатай байна: Хяналтын тогтолцооны шинэчлэлийг эрх зүйн шинэчлэлтэй хамт хийх шаардлагатай.

Хяналт шалгалтын давхардлыг бууруулах, арилгах шаардлагатай байна: Аж ахуйн нэгж, байгууллагад салбаруудын хяналт шалгалтын давхардал байгаа нь цаг хугацааны болон зардлын дарамт үүсгэж, нөгөө талаар хяналт шалгалтын үр дүн, төрийн үйлчилгээний үр ашиг буурч байна.

Хяналтыг салбарын хяналтын бүтэц, зохион байгуулалтаар ажиллуулах нь оновчгүй байна: Салбар тус бүрийн хяналтын тогтолцоо нь оновчгүй, уялдаа сул, хяналт шалгалтын стандарт, арга зүй харилцан адилгүй, хяналт шалгалтууд нэгдсэн төлөвлөлтгүйгээр хийгдэж байгаа нь иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад хүндрэл учруулж байна.

Хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна: Хяналт шалгалтыг хяналтын чиглэл бүрээр хамтарч давхардал үүсгэхгүйгээр хийх зохицуулалт тусгах, хяналт шалгалтын үр дүн, тайлан мэдээг УИХ-д тайлагнах, хуулийн хэрэгжилтэд үндэслэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй байх, хуулийн хэрэгжилт нь нийгмийн бодит байдал, эдийн засгийн индикатор болох бөгөөд ямар салбарын хууль чанга, сул байна вэ гэдгийг тодорхойлоход тусгах зэрэг болно.

2.5.Хуулийн төсөлд тусгах санал


Хууль, эрх зүйн орчныг шинэчлэхэд дараах асуудлуудыг тусгах зайлшгүй шаардлагатай. Үүнд:

- Хараат бус байдлын баталгааг хуульчлах;
- Төрийн тусгай чиг үүргийн ангилалд хамруулах, нийцсэн цалин нэмэгдэл;
- Улсын байцаагчийн мэргэжлийн шийдвэр гаргах эрхийг баталгаажуулах;
- Нийгмийн баталгааг хангуулах, хууль зүйн хамгаалалтыг тусгах. Тухайлбал: шүүх, мөрдөн шалгах байгууллагад тайлбар өгөх, хэрэг маргаанд хохирогчоор оролцох үед төрөөс өмгөөлөл үзүүлэх;
- Мэргэжлийн бие даасан байдлыг хамгаалах, мэргэжлийн үнэлгээ, дүгнэлт гаргасных нь төлөө ялгаварлан гадуурхах, шахах, сүрдүүлэх, нэр хүндэд нь халдах үйлдлийг хориглож, зөрчсөн тохиолдолд хуулийн хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг хуульд тусгах.
- Санхүүгийн хяналт, Хилийн хяналт, Эмийн хяналт, Мал эмнэлгийн хяналт зэрэг Мэргэжлийн хяналтын байгууллагаас салгасан бүх хяналтыг буцаан нэгтгэх;
- Хяналт шалгалт хийх арга хэлбэрийг тодорхой тусгах;
- Хяналт шалгалтыг урьдчилан мэдэгдэх шаардлагагүй зохицуулалтыг тусгах;

3.1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Цахим судалгаанд 1042, И-монголиа төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системээр 10219, нийт 11261 иргэн, хуулийн этгээд тус тус судалгаанд хамрагдсан. Үүнээс нас тодорхойгүй 113, хүйс тодорхойгүй 42, салбар тодорхойгүй 664, бусад шалтгаанаар 164, нийт 983 оролцогчийн мэдээллийг хасч, 10278 иргэн, хуулийн этгээдийн хариулсан хариултад дүн шинжилгээ хийлээ. Үүнээс 97.1 хувь буюу 9981 иргэн, 2.9 хувь буюу 297 хуулийн этгээд судалгаанд оролцсон байна.

График 26. Судалгаанд хамрагдагчдын нас, хүйсийн бүтэц, тоогоор



Судалгаанд хамрагдсан нийт 297 хуулийн этгээдийн төлөөллийг авч үзвэл 130 буюу 43.8 хувь нь эмэгтэй, 163 буюу 54.9 хувь нь эрэгтэй, 1.3 хувь буюу 4 нь хариулахгүй гэсэн байна.

Харин судалгаанд хамрагдсан нийт 9981 иргэний 4842 буюу 48.5 хувь нь эмэгтэй, 5121 буюу 51.3 хувь нь эрэгтэй, 18 буюу 0.2 хувь нь хариулах боломжгүй гэсэн байна.

Хуулийн этгээдийн төлөөлийн 6.7 хувь буюу 20 нь 55 ба түүнээс дээш, 21.2 хувь буюу 63 нь 45-54, 37.0 хувь буюу 110 нь 35-44, 21.2 хувь буюу 63 нь 25-34, 11.7 хувь буюу 35 нь 19-24, 0.6 хувь 2 нь 18-аас доош настай байна.

Иргэний 0.03 хувь буюу 3 нь 18-аас доош, 17.5 хувь буюу 1756 нь 19-24, 34.7 хувь буюу 3464 нь 25-34, 31.1 хувь буюу 3114 нь 35-44, 14.0 хувь буюу 1402 нь 45-54, 5.1 хувь буюу 511 нь 55 ба түүнээс дээш насны иргэд байна.

Хүснэгт 4. Судалгаанд хамрагдсан иргэн, хуулийн этгээдийн тоо, салбараар

Салбар	НИЙТ	Үүнээс		НИЙТ, хувиар	Үүнээс	
		Иргэн	Хуулийн этгээд		Иргэн	Хуулийн этгээд
Авто зам, авто тээвэр	578	561	17	5.6	5.6	5.7

Аялал жуулчлал, зочид буудал, амралтын газар	257	242	15	2.5	2.4	5.1
Байгаль орчин	97	89	8	0.9	0.9	2.7
Барилга, хот байгуулалт	1006	975	31	9.8	9.8	10.4
Боловсрол	1033	1013	20	10.1	10.1	6.7
Бусад	2422	2366	56	23.6	23.7	18.9
Жижиглэнгийн болон бөөний худалдаа, үйлчилгээ	731	697	34	7.1	7.0	11.4
Мэдээлэл, холбоо	320	314	6	3.1	3.1	2.0
Соёл, спорт	181	173	8	1.8	1.7	2.7
Төрийн байгууллага	94	89	5	0.9	0.9	1.7
Уул уурхай, олборлолт	1089	1078	11	10.6	10.8	3.7
Хоол, хүнс үйлдвэрлэл, үйлчилгээ	891	866	25	8.7	8.7	8.4
Хөдөлмөр, нийгмийн хамгаалал	277	261	16	2.7	2.6	5.4
Хөдөө аж ахуй	285	268	17	2.8	2.7	5.7
Эрүүл мэнд	740	721	19	7.2	7.2	6.4
Эрчим хүч	277	268	9	2.7	2.7	3.0
НИЙТ	10278	9981	297	100.0	100.0	100.0

Судалгаанд хамрагдсан оролцогчдыг үйл ажиллагаа явуулж буй салбараар авч үзвэл уул уурхай, олборлолт 1,089 оролцогч (10.6 хувь), боловсрол 1,033 оролцогч (10.1 хувь), барилга, хот байгуулалт 1,006 оролцогч (9.8 хувь)-тайгаар хамгийн өндөр хувийг эзэлж байна. Мөн хоол, хүнс үйлдвэрлэл, үйлчилгээ (891 буюу 8.7 хувь), эрүүл мэнд (740 буюу 7.2 хувь), жижиглэнгийн болон бөөний худалдаа, үйлчилгээ (731 буюу 7.1 хувь), авто зам, авто тээвэр (578; 5.6 хувь) зэрэг салбарын төлөөлөл хамрагдсан байна.

Хуулийн этгээдийн төлөөллийн хувьд жижиглэнгийн болон бөөний худалдаа, үйлчилгээ (34 байгууллага буюу 11.4 хувь), барилга, хот байгуулалт (31 байгууллага буюу 10.4 хувь), хоол, хүнс үйлдвэрлэл, үйлчилгээ (25 байгууллага буюу 8.4 хувь), боловсрол (20 байгууллага буюу 6.7 хувь), эрүүл мэнд (19 байгууллага буюу 6.4 хувь)-ийн салбарын төлөөлөл харьцангуй өндөр байна. Харин байгаль орчин, соёл, спорт, мэдээлэл, холбоо, төрийн байгууллага зэрэг салбаруудад хуулийн этгээдийн оролцоо бага байв.

Хүснэгт 5. Судалгаанд хамрагдагчдын тухайн салбарт ажилласан хугацаа, тоо, хувиар

№	Ажилласан хугацаа	НИЙТ	Үүнээс		НИЙТ хувиар	Үүнээс	
			Иргэн	Хуулийн этгээд		Иргэн	Хуулийн этгээд
1.	1 жил хүртэл	1975	1931	44	19.2	19.3	14.8
2.	1-3 жил	2411	2358	53	23.5	23.6	17.8
3.	4-9 жил	2710	2633	77	26.4	26.4	25.9
4.	10-14 жил	1442	1391	51	14.0	13.9	17.2
5.	15-19 жил	803	777	26	7.8	7.8	8.8

6.	20-оос дээш жил	937	891	46	9.1	8.9	15.5
	НИЙТ	10278	9981	297	100.0	100.0	100.0

Судалгаанд хамрагдсан иргэн, хуулийн этгээдийг ажилласан хугацаагаар нь авч үзвэл 4–9 жил ажилласан оролцогчид хамгийн өндөр буюу 26.4 хувь (2,710 хүн) байна. Түнчлэн судалгаанд оролцогчдын 1–3 жил ажилласан 23.5 хувь (2,411 хүн), 1 жил хүртэл ажилласан 19.2 хувь (1,975 хүн), 10–14 жил ажилласан 14.0 хувь (1,442), 20-оос дээш жил ажилласан 9.1 хувь (937 хүн), 15–19 жил ажилласан 7.8 хувь (803 хүн) байна.

Иргэдийн хувьд ажилласан хугацааны бүтэц нийт оролцогчдын бүтэцтэй төстэй бөгөөд 4–9 жил ажилласан иргэд 26.4 хувь, 1–3 жил ажилласан иргэд 23.6 хувь, 1 жил хүртэл ажилласан иргэд 19.3 хувь-ийг эзэлж байна. Харин хуулийн этгээдийн хувьд 4–9 жил үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд хамгийн өндөр буюу 25.9 хувь бөгөөд үүний дараа 1–3 жил (17.8 хувь), 10–14 жил (17.2 хувь), 20-оос дээш жил (15.5 хувь), 1 жил хүртэл (14.8 хувь), 15–19 жил (8.8 хувь) ажилласан байгууллагууд оржээ.

Ерөнхийд нь авч үзвэл судалгаанд оролцогчдын бараг тал хувь (49.9 хувь) нь 1–9 жилийн ажлын туршлагатай бөгөөд 10 ба түүнээс дээш жилийн туршлагатай оролцогчид 30.9 хувийг эзэлж байна.

3.2.Судалгааны үр дүн

Мэргэжлийн хяналтын тогтолцооны иргэд, хуулийн этгээдтэй хамтран ажиллаж буй байдал, чиг хандлага, тулгамдсан асуудал, цаашид сайжруулах талаарх олон нийт, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийн санал, байр суурийг тодорхойлох хэсгийн санал асуулга нь дараах бүрдэлтэй. Үүнд:

Хүснэгт 6.Мэргэжлийн хяналтын тогтолцооны талаар иргэд, хуулийн этгээдээс авах судалгааны асуулт, хариултын тоо, агуулга

№	Асуулт	Хариултын тоо	Агуулга
1	Сүүлийн 3 жилийн хугацаанд салбарын хяналт (хуучнаар мэргэжлийн хяналт)-ын байгууллагатай харилцсан уу?	3	Тийм
			Үгүй
			Санахгүй байна.
2	Тийм бол ямар хэлбэрээр харилцсан бэ?	4	Зөвлөн туслах үйлчилгээ авсан.
			Дүгнэлт гаргуулсан.
			Сургалт, семинарт хамрагдсан.
			Бусад
3	Салбарын хяналтын үйл ажиллагаанд үнэлгээ өгнө үү. (Хариулт тус бүр	9	Хяналт шалгалтын явцад өгсөн зөвлөгөө, мэдээлэл ойлгомжтой, хүртээмжтэй байсан.

	“сайн”, “муу”, “дунд зэрэг” гэсэн 3 сонголттой)		Хяналт шалгалтын зорилго, хамрах хүрээ тодорхой, ойлгомжтой байсан. Хяналт шалгалтын дүгнэлт, шийдвэр нь шударга, үндэслэлтэй байсан. Улсын байцаагч нь ашиг сонирхлын зөрчилгүй ажилласан. Улсын байцаагчийн ёс зүй, харилцаа, хандлага сайн байсан. Хяналт шалгалт нь эрсдэлээс урьдчилан сэргийлж, зөрчил гарахаас хамгаалсан. Илэрсэн зөрчлийг арилгахад арга зүйн дэмжлэг үзүүлсэн. Хүндрэл, чирэгдэл учруулаагүй. Үндсэн үйл ажиллагаанд саад учруулаагүй.
4	Өнгөрсөн 3 жилийн хугацаанд танай байгууллагад жилд дунджаар хэдэн удаа салбарын хяналтын хяналт шалгалт хийгдсэн бэ?	5	1 удаа 2-3 удаа 4-5 удаа 5-7 удаа 7 ба түүнээс дээш удаа
5	Хяналт шалгалт танай үйл ажиллагаанд хүндрэл учруулдаг уу?	3	Тийм Үгүй Мэдэхгүй
6	Тийм бол үнэлнэ үү. (Хариулт тус бүр “маш бага”, “бага”, “дунд зэрэг”, “их”, “маш их” гэсэн 5 сонголттой)	6	Хяналт шалгалтыг өөр өөр чиглэлээр давтамжтай, ялгаатай хугацаанд зохион байгуулдаг нь ачаалал үүсгэдэг. Нэг чиглэлийн хяналт шалгалт давхардаж хийгддэг. Хяналт шалгалтын бичиг баримтын давхардал их, зарим хяналтын хуудасны агуулга ижил байдаг. Хяналт шалгалтыг төлөвлөсөн хугацаандаа багтаан дуусгадаггүй. Зөвлөн туслах, арга зүйн дэмжлэг үзүүлдэггүй. Урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах арга хэмжээнээс илүүтэйгээр хариуцлага, торгуулийн арга хэмжээг түлхүү хэрэгжүүлдэг.
7	Мэргэжлийн хяналтын байгууллагыг татан буулгаснаар ямар үр дагавар үүссэн гэж та бодож байна вэ? (Хариулт тус бүр “сайжирсан”, “суларсан”, “хэвээрээ” гэсэн 3 сонголттой)	8	Хүнсний аюулгүй байдлын хяналт Барилга байгууламжийн чанар, аюулгүй байдлын хяналт Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалт Хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөрийн хяналт Байгаль орчны хяналт Хүн, хуулийн этгээдэд зөвлөн туслах боломж Дүрэм, журмын хяналт

			Хяналтын байгууллагуудын уялдаа холбоо, зохицуулалтын үр нөлөө
8	Мэргэжлийн хяналтын байгууллагыг дахин байгуулах шаардлагатай юу?	3	Тийм, зайлшгүй шаардлагатай.
			Шаардлагагүй, одоогийн тогтолцоо хангалттай.
			Мэдэхгүй.
9	Тийм бол гарах үр нөлөөг үнэлнэ үү. (Хариулт тус бүр “санал нийлнэ”, “зарим талаар санал нийлнэ”, “санал нийлэхгүй” гэсэн 3 сонголттой)	6	Хяналт шалгалтын давхардал буурна.
			Хяналтын чанар, үр дүн сайжирна.
			Хүн, хуулийн этгээдэд зөвлөн туслах боломж нэмэгдэнэ.
			Мэргэжлийн хяналтын нэр хүнд өснө.
			Хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөлт, зохион байгуулалт сайжирна.
			Нийтийн аюулгүй байдал сайжирна.
10	Таны бодлоор хяналтын ямар тогтолцоо хамгийн оновчтой вэ?	5	Мэргэжлийн хяналтын нэгдсэн тогтолцоо
			Салбарын хяналтын хэлбэрээр ажиллахад асуудалгүй
			Шинэ зарчим, бүтэц бүхий хяналтын тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай
			Бусад
			Мэдэхгүй

Дээрх асуултуудад хариулсан байдлыг товч нэгтгэв.

Сүүлийн 3 жилийн хугацаанд салбарын хяналт (хуучнаар мэргэжлийн хяналт)-ын байгууллагатай харилцсан байдал

График 27.Иргэн, хуулийн этгээдийн сүүлийн 3 жилд салбарын хяналтын байгууллагатай хамтран ажилласан байдал, тоогоор



Судалгаанд хамрагдсан иргэн, хуулийн этгээдийн дийлэнх буюу иргэдийн 80.9 хувь, хуулийн этгээдийн 63.0 хувь нь сүүлийн гурван жилийн хугацаанд мэргэжлийн хяналтын байгууллагатай харилцаагүй гэж хариулсан байна.


Харин мэргэжлийн хяналтын байгууллагатай иргэдийн 18.3 хувь, хуулийн этгээдийн 35.0 хувь харилцсан гэж хариулсан бөгөөд энэ нь хуулийн этгээдүүд мэргэжлийн хяналтын байгууллагатай иргэдээс харьцангуй илүү давтамжтай харилцдаг болохыг харуулж байна. Судалгаанд оролцогчдын маш бага хувь нь

тухайн асуултад "Санахгүй байна" гэж хариулсан бөгөөд энэ үзүүлэлт иргэдийн 0.7 хувь, хуулийн этгээдийн 2.0 хувь байна.

Иргэн, хуулийн этгээдийн мэргэжлийн хяналтын байгууллагатай харилцсан хэлбэр

Сүүлийн 3 жилийн хугацаанд салбарын хяналтын байгууллагатай харилцсан гэж хариулсан 104 хуулийн этгээдийн төлөөлөл, 1830 иргэнээс ямар хэлбэрээр харилцсан болохыг тодруулсан.

График 28. Иргэн, хуулийн этгээдийн сүүлийн 3 жилд салбарын хяналтын байгууллагатай хамтран ажилласан байдал, хувиар




Сүүлийн гурван жилийн хугацаанд салбарын хяналтын байгууллагатай харилцсан гэж хариулсан иргэн, хуулийн этгээдээс харилцааны хэлбэрийг тодруулахад хяналт шалгалтад хамрагдсан гэж хариулсан оролцогчид хамгийн өндөр хувийг эзэлжээ. Тодруулбал, иргэдийн 54.7 хувь, хуулийн этгээдийн 58.5 хувь нь хяналт шалгалтад хамрагдсан гэж хариулсан нь салбарын хяналтын байгууллагатай үүссэн харилцааны үндсэн хэлбэр байгааг харуулж байна.

Үүний дараа зөвлөн туслах үйлчилгээ авсан гэж иргэдийн 16.9 хувь, хуулийн этгээдийн 16.0 хувь хариулсан бөгөөд энэ үзүүлэлт иргэн, хуулийн этгээдийн аль алиных нь хувьд ойролцоо байна. Харин дүгнэлт гаргуулсан гэж хариулсан хуулийн этгээдийн эзлэх хувь (16.0 хувь) иргэдийнхээс (7.8 хувь) хоёр дахин өндөр байна.

Мөн сургалт, семинарт хамрагдсан гэж иргэдийн 16.1 хувь, хуулийн этгээдийн 4.7 хувь хариулсан нь иргэд мэдээлэл, сургалтын арга хэмжээнд харьцангуй илүү хамрагддаг болохыг илэрхийлж байна. Харин бусад хэлбэрээр харилцсан гэж иргэдийн 4.5 хувь, хуулийн этгээдийн 4.7 хувь хариулжээ.

Салбарын хяналтын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ

График 29. Үйлчилгээ авсан иргэн, хуулийн этгээдийн салбарын хяналтын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ, хувиар



Салбарын хяналтын байгууллагаас үйлчилгээ авсан иргэн, хуулийн этгээдээс хяналтын үйл ажиллагааны чанар, хүртээмжийг хэд хэдэн үзүүлэлтээр үнэлүүлсэн.

"Хяналт шалгалт нь эрсдэлээс урьдчилан сэргийлж, зөрчил гарахаас хамгаалсан" гэж оролцогчдын 54.3 хувь, "Улсын байцаагч ашиг сонирхлын зөрчилгүй ажилласан" (53.6 хувь), "Хяналт шалгалтын зорилго, хамрах хүрээ тодорхой, ойлгомжтой байсан" (53.8 хувь), "Хяналт шалгалтын явцад өгсөн зөвлөгөө, мэдээлэл ойлгомжтой, хүртээмжтэй байсан" (50.4 хувь) зэрэг үзүүлэлтүүд харьцангуй өндөр үнэлгээ авчээ.

Мөн үндсэн үйл ажиллагаанд саад учруулаагүй (49.6 хувь), илэрсэн зөрчлийг арилгахад арга зүйн дэмжлэг үзүүлсэн (47.8 хувь), улсын байцаагчийн ёс зүй, харилцаа хандлага сайн байсан (48.4 хувь), хяналт шалгалтын дүгнэлт, шийдвэр шударга, үндэслэлтэй байсан (46.9 хувь) болон хяналт шалгалтын үйл ажиллагаа хууль, журамд нийцсэн (46.1 хувь) гэсэн өндөр хувьтай байна.


Харин "Илэрсэн зөрчлийг арилгахад арга зүйн дэмжлэг үзүүлсэн" (23.1 хувь), "Хяналт шалгалт нь эрсдэлээс урьдчилан сэргийлж, зөрчил гарахаас хамгаалсан" (18.5 хувь) гэсэн үзүүлэлтүүд харьцангуй бага үнэлгээтэй байна.

Ерөнхийд нь авч үзвэл, иргэн, хуулийн этгээдийн хариултын сонголт ойролцоо байна.

Өнгөрсөн 3 жилийн хугацаанд тухайн байгууллагад хийсэн хяналт шалгалтын тооны мэдээлэл

Өнгөрсөн 3 жилийн хугацаанд танай байгууллагад жилд дунджаар хэдэн удаа хяналт шалгалт хийсэн талаар тодруулсан.

График 30. Сүүлийн 3 жилийн хугацаанд жилд дундажаар иргэн, хуулийн этгээдийн хяналт шалгалтад хамрагдсан байдал, хувиар



Сүүлийн гурван жилийн хугацаанд салбарын хяналтын байгууллагын хяналт шалгалтад хамрагдсан иргэн, хуулийн этгээдээс жилд дундажаар хэдэн удаа хяналт шалгалт хийсэн талаар тодруулахад иргэдийн 43.6 хувь, хуулийн этгээдийн 50.0 хувь нь жилд дундажаар 2–3 удаа хяналт шалгалтад хамрагдсан гэж хариулсан байна.


Мөн 1 удаа хяналт шалгалтад хамрагдсан гэж иргэдийн 28.9 хувь, хуулийн этгээдийн 28.8 хувь хариулсан бөгөөд энэ үзүүлэлт хоёр бүлгийн хувьд бараг ижил түвшинд байна. Харин жилд 4–5 удаа хяналт шалгалт хийлгэсэн гэж иргэдийн 14.9 хувь, хуулийн этгээдийн 10.6 хувь хариулсан байна.

Харьцангуй өндөр давтамжтай буюу жилд 5–7 удаа хяналт шалгалтад хамрагдсан гэж иргэдийн 3.4 хувь, хуулийн этгээдийн 5.8 хувь, жилд 7 ба түүнээс дээш удаа хяналт шалгалтад хамрагдсан гэж иргэдийн 9.2 хувь, хуулийн этгээдийн 4.8 хувь тус тус хариулжээ.

Хяналт шалгалт үйл ажиллагаанд нь хүндрэл учруулдаг эсэх

Хяналт шалгалт иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хүндрэл учруулдаг эсэхийг тодруулсан.

График 31. Иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хийж байгаа хяналт шалгалт хүндрэл учирдаг эсэх, хувиар



Судалгаанд оролцогчдоос салбарын хяналт шалгалт үйл ажиллагаанд нь хүндрэл учруулдаг эсэхийг тодруулахад "Үгүй" гэж иргэдийн 50.3 хувь, хуулийн этгээдийн 56.7 хувь нь хариулжээ.


Харин хяналт шалгалт хүндрэл учруулдаг гэж иргэдийн 32.5 хувь, хуулийн этгээдийн 34.6 хувь хариулсан бөгөөд хоёр бүлгийн хоорондын ялгаа төдийлөн их биш байна. Мөн "Мэдэхгүй" гэж хариулсан иргэдийн эзлэх хувь 17.2 хувь, хуулийн этгээдийнх 8.7 хувь байгаа нь иргэдийн дунд энэ асуудлаар тодорхой байр суурь илэрхийлээгүй оролцогчдын эзлэх хувь харьцангуй өндөр байгааг харуулж байна.

Ерөнхийд нь авч үзвэл, оролцогчдын гуравны нэг орчим нь хяналт шалгалт тодорхой хэмжээгээр хүндрэл учруулдаг гэж үзсэн нь хяналт шалгалтын төлөвлөлт, зохион байгуулалт, хэрэгжилтийн явцад хянуулж буй этгээдийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг бууруулах чиглэлээр анхаарах шаардлагатайг илтгэж байна.

Хяналт шалгалтын улмаас иргэн, хуулийн этгээдэд учирч байгаа хүндрэл

Хяналт шалгалт хийхтэй холбоотой үйл ажиллагаанд нь хүндрэл учирдаг гэж хариулсан 595 иргэн, 36 хуулийн этгээд ямар хүндрэл учруулдаг талаар үнэлсэн.

График 32.Иргэний үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх хүрээнд учирдаг хүндрэлийг үнэлсэн байдал, тоогоор



Хяналт шалгалт нь үйл ажиллагаанд нь хүндрэл учруулдаг гэж хариулсан иргэн, хуулийн этгээдээс ямар хүндрэл тулгардаг талаар тодруулахад хэд хэдэн асуудалд "их" болон "маш их" гэсэн үнэлгээ давамгайлсан байна.

Хамгийн ихээр хүндрэл учруулдаг асуудал нь хяналт шалгалтыг өөр өөр чиглэлээр, давтамжтай, ялгаатай хугацаанд зохион байгуулдаг явдал байсан бөгөөд оролцогчдын 22.6 хувь нь "их", 44.4 хувь нь "маш их" хүндрэл учруулдаг гэж үнэлсэн байна. Мөн нэг чиглэлийн хяналт шалгалт давхардан хийгддэг асуудлыг 39.4 хувь нь "их", 21.9 хувь нь "маш их", хяналт шалгалтын бичиг баримтын давхардал их байдлыг 42.7 хувь нь "их", 21.1 хувь нь "маш их" хүндрэл учруулдаг гэж үзжээ.

Түүнчлэн урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах арга хэмжээнээс илүүтэйгээр хариуцлага тооцоход чиглэдэг гэсэн асуудлыг оролцогчдын 36.5 хувь нь "их", 19.4 хувь нь "маш их", хяналт шалгалт төлөвлөсөн хугацаандаа багтан дуусдаггүй гэсэн асуудлыг 33.2 хувь нь "их", 15.9 хувь нь "маш их" хүндрэл учруулдаг гэж үнэлсэн байна. Харин зөвлөн туслах, арга зүйн дэмжлэг үзүүлдэггүй гэсэн асуудалд оролцогчдын 28.0 хувь нь "их", 15.6 хувь нь "маш их", 37.7 хувь нь "дунд зэрэг" гэж үнэлжээ.

Хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотойгоор оролцогчдын хамгийн ихээр онцолсон хүндрэл нь олон байгууллагын давхардсан болон давтамжтай хяналт шалгалт, бичиг баримтын давхардал, мөн хариуцлага тооцох чиглэл давамгайлсан хандлага байв. Харин зөвлөн туслах үйлчилгээ, арга зүйн дэмжлэгийн хүртээмж, хяналт шалгалтын хугацааны зохион байгуулалттай холбоотой асуудлууд мөн тодорхой түвшинд хүндрэл үүсгэж байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Мэргэжлийн хяналтын байгууллагыг татан буулгаснаар үүссэн үр дагавар

Мэргэжлийн хяналтын байгууллагыг татан буулгаснаар ямар үр дагавар үүсэн талаар судалгаанд оролцсон 9981 иргэн, 297 хуулийн этгээдээс асууж, дараах үнэлгээг хийсэн.

График 33. Мэргэжлийн хяналтыг татан буулгаснаар үүссэн үр дагаврын талаарх иргэн, хуулийн этгээдийн үнэлгээ, хувиар



Судалгаанд оролцогчдоос мэргэжлийн хяналтын байгууллагыг татан буулгаж, чиг үүргийг салбарын байгууллагуудад шилжүүлсний үр нөлөөг үнэлүүлэхэд ихэнх үзүүлэлтээр "суларсан" гэсэн үнэлгээ давамгайлсан байна. Харин "сайжирсан" гэж үзсэн оролцогчдын эзлэх хувь бүх үзүүлэлтэд 8–12 хувийн хооронд байгаа нь харьцангуй бага байна.

Иргэдийн үнэлгээгээр хамгийн ихээр суларсан гэж үзсэн чиглэлүүд нь хүнсний аюулгүй байдлын хяналт (57.2 хувь), барилга байгууламжийн чанар, аюулгүй байдлын хяналт (55.9 хувь), байгаль орчны хяналт (51.6 хувь), эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт (50.3 хувь) болон хяналтын байгууллагуудын уялдаа холбоо (49.2 хувь) байна. Харин хүн, хуулийн этгээдэд зөвлөн туслах үйл

ажиллагаа хамгийн өндөр буюу 45.8 хувь нь хэвээрээ гэж үнэлсэн нь бусад үзүүлэлттэй харьцуулахад тогтвортой үнэлгээ авчээ.


Хуулийн этгээдийн үнэлгээнд мөн адил суларсан гэсэн хариулт давамгайлсан бөгөөд хүнсний аюулгүй байдлын хяналт (56.9 хувь), барилга байгууламжийн чанар, аюулгүй байдлын хяналт (57.2 хувь), эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт (56.6 хувь) зэрэг чиглэлүүд хамгийн өндөр хувиар суларсан гэж үнэлэгдсэн байна. Түүнчлэн хяналтын байгууллагуудын уялдаа холбоо (53.9 хувь), дүрэм, журам, стандартын хэрэгжилт (51.9 хувь) болон байгаль орчны хяналт (51.9 хувь) ч мөн адил олонхийн үнэлгээгээр суларсан гэж үзжээ.

Ерөнхийдөө судалгаанд хамрагдсан иргэн, хуулийн этгээдийн үнэлгээгээр мэргэжлийн хяналтын байгууллагыг татан буулгаж, чиг үүргийг салбарын байгууллагуудад шилжүүлсний дараа хяналтын тогтолцооны үндсэн чиглэлүүд, тухайлбал хүнсний аюулгүй байдал, барилгын чанар, эмийн хяналт, байгаль орчны хяналт болон байгууллага хоорондын уялдаа холбоо суларсан гэсэн үнэлгээ давамгайлж байна.

Мэргэжлийн хяналтын байгууллагыг дахин байгуулах шаардлагатай эсэх талаарх үзэл бодол

Судалгаанд оролцсон иргэн, хуулийн этгээдээс мэргэжлийн хяналтын байгууллагыг дахин байгуулах шаардлагатай эсэхийг тодруулсан.

График 34. Мэргэжлийн хяналтыг дахин байгуулах эсэх талаарх иргэн, хуулийн этгээдийн үзэл бодол, хувиар



Судалгаанд оролцогчдоос мэргэжлийн хяналтын байгууллагыг дахин байгуулах шаардлагатай эсэх талаар тодруулахад нийт оролцогчдын 47.5 хувь нь "Тийм, зайлшгүй шаардлагатай", 23.4 хувь нь "Шаардлагагүй, одоогийн тогтолцоо хангалттай", 2.9 хувь нь "Тийм, зарим чиглэлээр шаардлагатай", 26.2 хувь нь "Мэдэхгүй" гэж хариулсан байна.

Иргэдийн хувьд 47.7 хувь нь мэргэжлийн хяналтын байгууллагыг дахин байгуулах нь зайлшгүй шаардлагатай гэж үзсэн бол 23.2 хувь нь одоогийн тогтолцоо хангалттай гэж хариулжээ. Мөн 2.7 хувь нь зөвхөн зарим чиглэлд байгуулах шаардлагатай гэж үзсэн бөгөөд 26.4 хувь нь тодорхой байр суурь илэрхийлээгүй байна.


Хуулийн этгээдийн үнэлгээгээр 42.4 хувь нь мэргэжлийн хяналтын байгууллагыг дахин байгуулах нь зайлшгүй шаардлагатай гэж үзсэн бол 10.8 хувь нь зарим чиглэлээр байгуулах шаардлагатай гэж хариулсан байна. Өөрөөр хэлбэл, хуулийн этгээдийн 53.2 хувь нь ямар нэг хэлбэрээр мэргэжлийн хяналтын байгууллагыг дахин байгуулах шаардлагатай гэсэн байр суурийг илэрхийлжээ. Харин 27.6 хувь нь одоогийн тогтолцоог хангалттай гэж үзсэн бөгөөд 19.2 хувь нь тодорхой байр суурь илэрхийлээгүй байна.

Ерөнхийдөө мэргэжлийн хяналтын байгууллагыг дахин байгуулах шаардлагатай гэсэн байр суурь давамгайлж байгаа бөгөөд энэ хандлага иргэн, хуулийн этгээдийн аль алинд нь ажиглагдаж байна.

Мэргэжлийн хяналтыг дахин байгуулснаар гарах үр нөлөө

Мэргэжлийн хяналтыг дахин байгуулах шаардлагатай гэж үзсэн 5025 иргэн, 158 хуулийн этгээдийн хариултыг тус бүр авч үзэв.

График 35. Мэргэжлийн хяналтыг дахин байгуулснаар гарах үр нөлөөг иргэн үнэлсэн байдал, тоогоор



Мэргэжлийн хяналтын байгууллагыг дахин байгуулснаар гарах үр нөлөөний талаар иргэн, хуулийн этгээдийн үнэлгээг авч үзэхэд бүх үзүүлэлтэд эерэг хүлээлт давамгайлсан байна. Судалгаанд оролцогчдын олонх нь байгууллагыг дахин байгуулснаар хяналтын тогтолцооны үр нөлөө, зохион байгуулалт болон үйлчилгээний чанар сайжирна гэж үзжээ.

Иргэдийн хувьд нийтийн аюулгүй байдал сайжирна (61.4 хувь), хяналтын чанар, үр дүн сайжирна (60.4 хувь), хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөлт, зохион байгуулалт сайжирна (55.0 хувь), хүн, хуулийн этгээдэд зөвлөн туслах боломж нэмэгдэнэ (50.5 хувь) гэсэн үзүүлэлтүүдэд хамгийн өндөр хувьтай байна.


Хуулийн этгээдийн үнэлгээнд мөн адил эерэг үнэлгээ давамгайлсан бөгөөд нийтийн аюулгүй байдал сайжирна (69.6 хувь), хяналтын нэгдсэн төлөвлөлт, зохион байгуулалт сайжирна (65.2 хувь), хяналтын чанар, үр дүн сайжирна (63.9 хувь), хүн, хуулийн этгээдэд зөвлөн туслах боломж нэмэгдэнэ (60.1 хувь), хяналт шалгалтын давхардал буурна (51.3 хувь) гэсэн үнэлгээ өндөр хувьтай байна.

Ерөнхийд нь авч үзвэл, иргэн, хуулийн этгээдийн аль аль нь мэргэжлийн хяналтын байгууллагыг дахин байгуулснаар нийтийн аюулгүй байдал, хяналтын чанар, нэгдсэн төлөвлөлт, зохион байгуулалт, зөвлөн туслах үйлчилгээ сайжирна гэсэн хүлээлттэй байна.

Хяналтын тогтолцооны талаарх иргэн, хуулийн этгээдийн байр суурь

Судалгаанд оролцсон 9981 иргэн, 297 хуулийн этгээд, нийт 10278 хариулагч хяналтын тогтолцооны талаар дараах байр суурийг илэрхийлсэн байна.

График 36.Хяналтын тогтолцооны талаарх иргэн, хуулийн этгээдийн үзэл бодол, тодорхойлсон байдал, тоогоор



Судалгаанд оролцогчдын хяналтын тогтолцооны талаарх байр суурийг авч үзэхэд иргэн, хуулийн этгээдийн үнэлгээ тодорхой ялгаатай байна. Нийт дүнгээр оролцогчдын хамгийн олон хэсэг нь шинэ зарчим, бүтэц бүхий хяналтын тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай гэж үзсэн бөгөөд мэргэжлийн хяналтын нэгдсэн тогтолцоог бий болгох санал нэлээд их байна.

Иргэдийн хувьд шинэ зарчим, бүтэц бүхий хяналтын тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай гэсэн санал хамгийн өндөр, ойролцоогоор гуравны нэгийг эзэлжээ. Мөн мэргэжлийн хяналтын нэгдсэн тогтолцоог дэмжсэн иргэд тавны нэгээс илүү хувийг эзэлсэн байна. Харин салбарын хяналтыг одоогийн хэлбэрээр ажиллуулахад асуудалгүй гэж үзсэн иргэдийн хувь харьцангуй бага байв.

Хуулийн этгээдийн хувьд мэргэжлийн хяналтын нэгдсэн тогтолцоо болон салбарын хяналтыг одоогийн хэлбэрээр үргэлжлүүлэх саналууд ойролцоо, тус бүр дөрөвний нэгээс дээш хувийг эзэлжээ. Түүнчлэн шинэ зарчим, бүтэц бүхий тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай гэж үзсэн хуулийн этгээдийн хувь мөн өндөр байгаа бол “Мэдэхгүй” гэсэн хариулт иргэдтэй харьцуулахад бага байна.

Хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох талаарх санал асуулгын үр дүн

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хүрээнд хяналтын тогтолцоог боловсронгуй болгох,

шаардлагатай арга хэмжээний талаар иргэн, хуулийн этгээдээс нийт 477 санал ирсэнийг ангилан нэгтгэж дараах үндсэн асуудлуудыг тоймлов. Асуудлыг саналын тоотой харьцуулбал:

Хүснэгт 7.Хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох санал, дүнд эзлэх хувиар

№	Хяналт, шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох санал (ангилал)	Саналын тоо	Нийт дүнд эзлэх хувь
	Нийт санал	477	100%
1	Мэргэжлийн хяналтын байгууллага байх хэрэгтэй	70	14.7
2	Хяналтын нэгдсэн тогтолцоотой, нэгдсэн бодлоготой байх нь зөв	67	14
3	Хяналт хариуцлагатай байх хэрэгтэй	57	11.9
4	Бүтэц, тогтолцооны шинэчлэл хийх, цомхон чадварлаг байх	42	8.8
5	Хяналт шалгалт ил тод, шударга зарчимтай байх	34	7.1
6	Мэдлэг, ур чадвартай байцаагч ажиллуулах	31	6.5
7	Торгодог биш зөвлөдөг, засаж залруулдаг байх	20	4.2
8	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх	20	4.2
9	Мэргэжлийн хяналт татан буугдсан нь үйл ажиллагааны аюулгүй байдалд сөрөг нөлөөлөхүйц үр дүн үзүүлж байна.	17	3.6
10	Хяналт шалгалт цомхон байх, бүх чиглэл рүү биш	16	3.4
11	Хяналт шалгалт хөндлөнгийн хараат бус, бие даасан бүтэцтэй байх	13	2.7
12	Хяналт салбар салбартаа байх нь зөв	12	2.5
13	Хяналт шалгалтын давхардлыг бууруулах	11	2.3
14	Хууль, эрх зүйн орчныг сайжруулах	11	2.3
15	Хяналт шалгалт эрсдэлд суурилсан, программ хангамж сайн, цахим байх	11	2.3
16	Зөвлөн туслах, урьдчилан сэргийлэх хяналтын хэлбэрийг хэрэгжүүлэх	10	2.1
17	Лабораториудыг нэгтгэх, чадамжийг сайжруулах	7	1.5
18	Ёс зүйтэй, харилцаа хандлага зөв байх	7	1.5
19	Хяналтын байгууллагуудын уялдаа холбоо сул	6	1.3
20	Хяналт шалгалт хэрэггүй	6	1.3
21	Салбарын хяналт хөндлөнгийн хараат бус байж чадахгүй байна	4	0.8
22	Хяналт шалгалт муу байгаа	3	0.6
23	Хяналт шалгалт хийх талаар өмнө нь мэдэгдэж, удирдамжаа ирүүлдэг байх	2	0.4

Судалгааны үр дүнгээс харахад;

- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын дийлэнх олонх нь нэгдсэн удирдлага, бодлоготой хяналтын нэгдсэн тогтолцоо шаардлагатай гэж үзсэн байна. Тухайлбал, “Мэргэжлийн хяналтын байгууллага байх хэрэгтэй” гэж 14.7 хувь, “Хяналтын нэгдсэн тогтолцоотой, нэгдсэн бодлоготой байх нь зөв” гэж 14.0 хувь нь үзсэн бөгөөд хамгийн өндөр хувийг эзэлжээ.
- Судалгаанд оролцогчид хяналт шалгалтын үйл ажиллагаа нь зөвхөн зөрчил илрүүлэхээс гадна хариуцлагатай, ил тод, шударга зарчимд тулгуурласан байх

шаардлагатай гэж үзсэн байна. Тухайлбал: “Хариуцлагатай хяналт байх хэрэгтэй” гэж 11.9 хувь, “Хяналт шалгалт ил тод, шударга зарчимтай байх” гэж 7.1 хувь нь хариулжээ.

- Хяналтын байгууллагын бүтэц, тогтолцоог шинэчлэхдээ чадварлаг, мэргэшсэн хүний нөөцтэй, цомхон бүтэцтэй байх шаардлага өндөр байна. Оролцогчдын 8.8 хувь нь “Бүтэц, тогтолцооны шинэчлэл хийх шаардлагатай” гэж үзсэн бол 6.5 хувь нь “Мэдлэг, ур чадвартай байцаагч ажиллуулах”-ыг онцолсон байна.
- Хяналт шалгалтын арга барилын хувьд торгууль, шийтгэлээс илүүтэйгээр зөвлөн туслах, урьдчилан сэргийлэх хэлбэртэй байх шаардлагатай гэсэн байр суурь түгээмэл байна. “Торгодог биш зөвлөдөг, засаж залруулдаг байх” гэж 4.2 хувь, “Зөвлөн туслах, урьдчилан сэргийлэх хяналтын хэлбэрийг хэрэгжүүлэх” гэж 2.1 хувь нь үзсэн нь энэ хандлагыг илэрхийлж байна.
- Хяналт шалгалтын байгууллага нь авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, хөндлөнгийн нөлөөнөөс хараат бус байх шаардлагатайг онцолсон бөгөөд “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх” гэж 4.2 хувь, “хөндлөнгийн хараат бус бүтэцтэй байх” гэж 2.7 хувь нь үзсэн байна.

Мөн судалгаанд өгсөн саналаас харахад Мэргэжлийн хяналтын байгууллагыг татан буулгаснаас хойш хяналт шалгалтын уялдаа холбоо, үр нөлөө суларсан гэж үзэх хандлага ажиглагдаж байна. Зарим оролцогчид энэ нь үйлдвэрлэл, үйлчилгээний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байгаа талаар дурдсан байна.

Саналын хариултаас дүгнэн үзэхэд оролцогчдын ихэнх нь мэргэжлийн хяналтын нэгдсэн тогтолцоог сэргээх, хяналтын байгууллагын бие даасан байдлыг хангах, ил тод шударга зарчмыг мөрдүүлэх, чадварлаг хүний нөөц бүрдүүлэх, зөвлөн туслах болон урьдчилан сэргийлэх хяналтыг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

3.3.Бүлгийн дүгнэлт:

1. Мэргэжлийн хяналтын нэгдсэн тогтолцоог сэргээх шаардлагатай.
2. Хяналт шалгалтын байгууллага бие даасан бүтэцтэй, хараат бус байх.
3. Хяналт шалгалт хариуцлагатай, ил тод, шударга зарчимд тулгуурласан байх.
4. Хяналтын байгууллагын бүтэц, тогтолцоог шинэчлэхдээ чадварлаг, мэргэшсэн хүний нөөцтэй, цомхон бүтэцтэй байх.
5. Хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ зөвлөн туслах, урьдчилан сэргийлэх хэлбэрийг түлхүү баримтлах.
6. Хяналт шалгалтын байгууллага нь авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, хөндлөнгийн нөлөөнөөс хараат бус байх.